Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн Мастер төлөвлөгөөг саад бэрхшээлгүй хэрэгжүүлэхэд дараах институтын бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлт, өөрчлөлтийг хийх шаардлагатай:

- Улаанбаатар хотын захиргаанд хатуу хог хаягдлын менежментийн асуудал хариуцах байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэх;
- Хатуу хог хаягдлын менежментийн санхүүгийн тогтолцоог сайжруулах

a. Хариуцах байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэх

Улаанбаатар хотын захиргаанд одоогийн хатуу хог хаягдлын менежментийн асуудал хариуцах байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэхийн тулд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч шинэ бүтэц бүхий Хот тохижилтын газар байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын 445 тоот захирамжийн хүрээнд 2006 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс байгуулав.

Захирамжийн дагуу Хот тохижилтын газрын удирдлага дараах зургийн дагуу байгууллагын шинэ бүтцийг бий болгож эхлэв. Хот тохижилтын газар дараах тооны ажилтан нарыг ажилд авахаар төлөвлөж байна.

Хуваарь	УБ хотын захиргаанаас томилон ажиллуулж цалинжуулах орон тоо	Хот тохижилтын газраас томилон ажиллуулж цалинжуулах орон тоо	Нийт
2006 оны эцсийн байдлаар	30	ЖАЙКА-ийн суурь судалгааны багийн зөвлөмжөөр	-
2008 оны эцсийн байдлаар	45	ЖАЙКА-ийн суурь судалгааны багийн зөвлөмжөөр	-

б. Хатуу хог хаягдлын менежментийн санхүүгийн тогтолцоог сайжруулах

б.1 Хог хаягдлын менежментийн үйлчилгээний хөлс

Судалгааны хүрээнд хийсэн санхүүгийн дүн шинжилгээн дээр үндэслэн хог хаягдлын менежментийн үйлчилгээний хөлсийг өөрчлөн шинэчилж 2006 оны 9 дүгээр сарын 1-нийн өдрөөс эхлэн мөрдүүлсэн. Дараах хүснэгтээр өмнөх болон шинэчилсэн тарифын хэмжээг үзүүлэв.

Хүснэгт 7-13: хог хаягдлын менежментийн үйлчилгээний хөлс

Үйлчилгээний нэр төрөл	Өмнөх тариф	Шинэ тариф
ААН-ийн хог хаягдал цуглуулах	1 машин буюу 4 тн хог тээвэрлэх зардал 19,000 төг	1 машин буюу 4 тн хог тээвэрлэх зардал 35,000 төг
Орон сууцны өрхийн хог хаягдал цуглуулах	200 төг/хүн/сар (өрхөөр тооцвол; 600 -1,000 төг/өрх/сар)	1,200 -2,000 төг/өрх/сар (дүүрэг дүүргээс хамаарна)
Гэр хорооллын өрхийн хог хаягдал цуглуулах	1,000 -1,500 төг/өрх/сар (дүүрэг дүүргээс хамаарна)	1,500 -2,500 төг/өрх/сар (дүүрэг дүүргээс хамаарна)
Зуслангийн өрхийн хог хаягдал цуглуулах	2,000 төг/өрх/сар	2,500 төг/өрх/сар
Нийтийн эзэмшил газар цэвэрлэх	18 төг/1м ²	50 төг/1м ²
Дарж булах	100 төг/1м ³	2,080 төг/тонн

б.2 Хог хаягдлын үйлчилгээний сан


Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн “Хог хаягдлын үйлчилгээний сангийн журам батлах тухай” 248 дугаар тогтоолыг үндэслэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Хог хаягдлын үйлчилгээний сан байгуулах тухай дараах захирамжийг гаргав:

- Нийслэлийн хог хаягдлын үйлчилгээний санг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дэргэд, дүүргүүдийн хог хаягдлын салбар санг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд тус тус байгуулах.
- Хог хаягдлын үйлчилгээний санг батлагдсан журмын дагуу зохион байгуулж бэлтгэл ажлыг хангуулан, 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн сангийн үйл ажиллагааг эхлүүлж, хяналт тавьж ажиллахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежер, дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгох.

Хог хаягдлын үйлчилгээний сан дээр үндэслэн Улаанбаатар хотын захиргаа/Хот тохижилтын газар нь дараах зургийн дагуу хатуу хог хаягдлын менежментийн одоогийн санхүүгийн тогтолцоог сайжруулах төлөвлөгөөтэй байна. Шинэ, хуучин тогтолцооны зөрүүг дараах байдлаар тодорхойлов.


- Нийслэлийн хог хаягдлын үйлчилгээний сан болон дүүргийн хог хаягдлын сан гэж хот болон дүүргүүдийн дэргэд тус тус байгуулав.

- ААН-ийн хогны төлбөрийг ТҮК-ийн байцагчийн оронд дүүргийн хог хаягдлын үйлчилгээний сангийн ажилтан цуглуулна.
- Гэр хорооллын өрхийн хогны төлбөрийг ТҮК-ийн байцагчийн оронд хороо эсвэл хэсгийн ажилтан цуглуулна
- Хот тохижилтын газрын хог хаягдал цуглуулах хэсэг эсвэл нэгж нь дүүргийн хог хаягдал цуглуулах үйлчилгээ үзүүлж дүүргийн хог хаягдлын үйлчилгээний сангаас санхүүжинэ.
- Нөөц компанийн оронд Хот тохижилтын газрын хог хаягдлыг дарж булах үйл ажиллагаа, менежментийг хангах нэгж хогийн төвлөрсөн цэг дээр хог хаягдлыг дарж булах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.




Зураг 7-7: Хот тохижилтын газрын бүтэц

Хатуу хог хаягдлын менежментийн
санхүүгийн тогтолцооны өнөөгийн байдал



Зураг 7-8: Хатуу хог хаягдлын менежментийн санхүүгийн одоогийн тогтолцоо



Зураг 7-9: Хатуу хог хаягдлын менежментийн санхүүгийн ирээдүйн тогтолцоо

7.8.3 Хувийн компанитай байгуулах гэрээний менежмент

Дүүргүүдийн ЗДТГ нь хог хаягдал цуглуулах үйлчилгээг хувийн компаниудаар гүйцэтгүүлэх шаардлага гарах тул тэдгээртэй байгуулах зохих гэрээний менежмент хийх нь нэн чухал юм. Тэрхүү менежментийг хийхийн тулд дараах асуудлуудыг анхаарах шаардлагатай.

а. Гэрээний тогтолцооны тухай санал

Хог хаягдал цуглуулах болон тээвэрлэх нийтлэг гурван төрлийн гэрээний тогтолцоо байдаг.

Хүснэгт 7-14: Гэрээний тогтолцооны эерэг болон сөрөг талууд

Гэрээний төрөл	Тайлбар	Захиалагчийн эерэг болон сөрөг талууд
Ажлын нийт үнийн дүнгээр хийх гэрээ	Гэрээний нийт дүнг тухайн нэг газар нутгийн хог хаягдлын гарах хэмжээний хандлагын дагуу хог хаягдлыг цуглуулах хэмжээ болон хугацааг үндэслэн тодорхойлдог. Энэхүү тогтолцоо нь хог хаягдлыг урьдчилан тооцоолох боломжтой тогтолцоонд тохирох буюу жишээлбэл, хүн амын тоо болон гарах хэмжээг урьдчилан тооцоолох боломжтой орон сууцны хог хаягдал цуглуулах тогтолцоонд тохиромжтой.	Эерэг талууд: Мониторинг болон хяналт хийхэд хялбар. Сөрөг талууд: Гэрээний үнийн дүнг тодорхойлохын тулд захиалагч нь хог хаягдал цуглуулах болон тээвэрлэх нийт зардлын тооцоог хийх шаардлагатай. Зардлын тооцоо хийх нь бага зэрэг хүндрэлтэй.
Жингийн хэмжээ –тээвэрлэх зайн дээр үндэслэн байгуулах гэрээ	Энэхүү тогтолцооны хүрээнд төлбөрийг хог хаягдлын жин болон тээвэрлэсэн зайн дээр үндэслэн хийдэг. Тээвэрлэх зайг нарийвчлан тодорхойлох нь нэлээд хүндрэлтэй байдаг тул ихэвчлэн тухайн бүс нутагт үнийн жишиг гэж тогтоодог. Төлбөрийг автопүүн дээр тээвэрлэн ирсэн нийт хог хаягдлын хэмжээ болон гэрээний дүнг үндэслэн тооцдог.	Эерэг талууд: Энэхүү гэрээний тогтолцоо нь хоёр талд хоюуланд нь шударга байх зарчмаар үйлчилдэг. Олон төрлийн хог хаягдал болон гарах хэмжээ нь хэлбэлздэг хог хаягдалд тохиромжтой тогтолцоо болно. Сөрөг талууд: Хуурах мэхлэх арга зам ихтэй тул гүйцэтгэгч тал нь хог хаягдлын хэмжээний тухай худал мэдээлэл өгөх нь олонтоо тохиолддог. Иймд төлбөрийн хэмжээ нэмэгдэх талтай байдаг. Тухайн машин нь хог хаягдлаа яг ямар бүс нутгаас цуглуулсан байдлыг тодорхойлоход хүндрэлтэй байдаг тул хяналтын ажлыг хийхэд нэлээд хүндрэлтэй.
Рейсийн тоогоор хийх гэрээ	Рейсийн тоо, нэг рейсээр тээвэрлэх тогтоосон хог хаягдлын хэмжээ болон тээвэрлэх зайн дээр үндэслэн төлбөр хийдэг. Тээвэрлэх зайг нарийвчлан тодорхойлох нь нэлээд хүндрэлтэй байдаг тул ихэвчлэн тухайн бүс нутагт үнийн жишиг гэж тогтоодог. Төлбөрийг нийт хийсэн рейсийн тоон дээр үндэслэн тооцдог.	Эерэг талууд: Энэхүү гэрээний тогтолцоо нь хоёр талд хоёуланд нь шударга байх зарчмаар үйлчилдэг. Гарах хэмжээ нь хэлбэлздэг хог хаягдалд тохиромжтой тогтолцоо болно. Сөрөг талууд: Тухайн машин нь хог хаягдлаа яг ямар бүс нутгаас цуглуулсан байдлыг тодорхойлоход хүндрэлтэй байдаг тул хяналтын ажлыг хийхэд нэлээд хүндрэлтэй.

Улаанбаатар хотын захиргааны менежментийн чадавхаас хамаарах хамгийн тохиромжтой гэрээний санал болгох тогтолцоог дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 7-15: Төлөвлөгөөт бүсийн санал болгох гэрээний тогтолцоо

Хог хаягдлын төрөл	Санхүүгийн эх үүсвэр	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх байгууллага	Төлбөрийн аргачлал	Тайлбар
Орон сууцны хог хаягдал	Хог хаягдлын үйлчилгээний сан	Дүүрэг	ТҮК	Нийт дүнгээр төлбөр хийх (Lump Sum)	Хороо бүрийн хог хаягдлын гарах хэмжээг хүн амын тоо болон нэг хүн нэг өдөрт хог хаях хэмжээгээр тооцож болно. Хороо бүрээс хогийн төвлөрсөн цэг хүртэл явах зайг тодорхойлон гаргаж болно. Улмаар хог хаягдлыг цуглуулах зардлыг тооцож болно. Мэдээллийн сан, түлшний үнэ, хүн амын тоо, нэг хүн нэг өдөрт хог хаях хэмжээ зэргийг жил болгон шинэчлэх шаардлагатай.
Зам талбайн цэвэрлэгээ	Одоогийн эх үүсвэр	Дүүрэг	ТҮК	Нийт дүнгээр төлбөр хийх (Lump Sum)	Одоогийн тогтолцоотой ижилхэн болно.
ААН-ийн хог хаягдал (үл хөдлөх хог хаях этгээд /тогмол нэг газар үйл ажиллагаа явуулах байгууллага)	Төсвийн хөрөнгө төлөвлөхгүй	Дүүрэг	ТҮК	Дүүрэг нь шууд хог хаях этгээдээс хогны төлбөрийг нь хураана.	ААН-ийн хогны төлбөрийг дүүрэг цуглуулна. Хот тохижилтын газар нь хог тээвэрлэх зай болон хог хаягдлын хэмжээг харгалзан дүүрэг бүрийн ААН-ийн хогны тарифын хамгийн тохиромжтой хэмжээг тогтоох асуудлыг хариуцана.
Түр хугацаатай бий болох нийтийн хог хаягдал	Хог хаягдал гаргаж буй этгээдээс шууд хураах (барилгын компани эсвэл захиалагч байгууллага)	Дүүрэг	ТҮК	Хогны хэмжээгээр	Дараагийн хуудаснаас үзнэ үү.
Жишээлбэл: зочид буудал, ресторан, албан контор, дэлгүүр, үйлдвэрийн газар					
ААН-ийн хог хаягдал (үйл ажиллагаа явуулах газраа байнга өөрчилдөг этгээд)					
Жишээлбэл: барилгын хог хаягдал					
Түр хугацаатай бий болох нийтийн хог хаягдал	Төсвийн хөрөнгө төлөвлөхгүй	Дүүрэг	ТҮК	Тухайн нөхцөл байдлыг харгалзан хамгийн тохиромжтой төлбөрийн тогтолцоог сонгох. <ul style="list-style-type: none"> ● Рейсийн тоогоор ● Тээвэрлэх жин хэмжээ болон зай эсвэл ● Нийт дүнгээр L.S. 	Тухайн арга хэмжээ бүрт төсөв төлөвлөх бөгөөд дүүрэг нь ТҮК-тэй гэрээ байгуулан ажиллана.
Жишээлбэл: Наадам, бусад арга хэмжээний хог хаягдал					
Түр хугацаатай бий болох хувийн этгээдийн хог хаягдал	Төсвийн хөрөнгө төлөвлөхгүй	Дүүрэг	ТҮК	Дүүрэг нь шууд хог хаях этгээдээс хогны төлбөрийг нь хураана.	ААН-ийн хог хаягдалтай ижил төрлийн арга хэмжээ авна.
Жишээлбэл: Овор ихтэй хог хаягдал, их хэмжээний хог хаягдал					

Хүснэгт 7-16: Төлөвлөгдөөгүй бүсийн санал болгох гэрээний тогтолцоо

	Санхүүгийн эх үүсвэр	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх байгууллага	Төлбөрийн аргачлал	Тайлбар
Орон сууцны хог хаягдал	Хог хаягдлын үйлчилгээний сан	Дүүрэг	ТҮК эсвэл бусад өөр хувийн компани	Рейсийн тоогоор эсвэл Нийт дүнгээр төлбөр хийх (Lump Sum)	Энэхүү тохиолдолд рейсийн тоогоор гэрээ хийх нь дараах ач холбогдолтой. <ul style="list-style-type: none"> Жижиг компани, тэр тусмаа ачааны машинтай хувь хүн ажиллуулах боломжтой Иймд хорооны зүгээс бие даагаад хогны машиныг зохицуулах боломжтой. Гэр хорооллын хогны хэмжээ улирлын чанартай өөр өөр байдаг тул рейсийн тоогоор гэрээ байгуулах нь шудрага юм. Хэрэв жижиг компани ажиллуулах тохиолдолд тэдгээр нь хогоо журмын дагуу тээвэрлэн хогийн цэгт хүргэж байгаа эсэхийг нарийн шалгаж байх зорилгоор манифест систем нэвтрүүлэх шаардлагатай.
Зам талбайн цэвэрлэгээ	Одоогийн эх үүсвэр	Дүүрэг	ТҮК	Нийт дүнгээр төлбөр хийх (Lump Sum)	Одоогоор гэр хороололд зам талбайн цэвэрлэгээний ажил байхгүй байна.
ААН-ийн хог хаягдал (үл хөдлөх хог хаях этгээд /логтмол нэг газар үйл ажиллагаа явуулах байгууллага) Жишээлбэл: з/б, ресторан, албан контор, дэлгүүр, үйлдвэрийн газар	Төсвийн хөрөнгө төлөвлөхгүй	Дүүрэг	ТҮК	Дүүрэг нь ААН-ээс хогны төлбөр хураана.	ААН-ийн хогны төлбөрийг дүүрэг цуглуулна. Хот тохижилтын газар нь хог тээвэрлэх зай болон хог хаягдлын хэмжээг харгалзан дүүрэг бүрийн ААН-ийн хогны тарифын хамгийн тохиромжтой хэмжээг тогтоох асуудлыг хариуцана.
ААН-ийн хог хаягдал (үйл ажиллагаа явуулах газраа байнга өөрчилдөг этгээд) Жишээлбэл: барилгын хог хаягдал	Хог хаягдал гаргаж буй этгээдээс шууд хураах (барилгын компани эсвэл захиалагч байгууллага)	Дүүрэг	ТҮК	Хог хаягдлын хэмжээгээр	Дараагийн хуудаснаас үзнэ үү.
Түр хугацаатай бий болох олон нийтийн хог хаягдал Жишээлбэл: Наадам, бусад арга хэмжээний хог хаягдал		Дүүрэг	ТҮК	Тухайн нөхцөл байдлыг харгалзан хамгийн тохирох төлбөрийн тогтолцоог сонгох. <ul style="list-style-type: none"> Рейсийн тоогоор Тээвэрлэх жин хэмжээ ба зай эсвэл Нийт дүнгээр L.S. 	Тухайн арга хэмжээ бүрт төсөв төлөвлөх бөгөөд дүүрэг нь ТҮК-тэй гэрээ байгуулан ажиллана.
Түр хугацаатай бий болох хувийн этгээдийн хог хаягдал Жишээлбэл: Овор ихтэй хог хаягдал, их хэмжээний хог хаягдал	Төсвийн хөрөнгө төлөвлөхгүй	Дүүрэг	ТҮК	Дүүрэг нь хог гаргах этгээдээс хогны төлбөр хураана.	ААН-ийн хог хаягдалтай ижил төрлийн арга хэмжээ авна.

b. Барилгын хог хаягдал хууль бусаар үүсэх байдлаас сэргийлэх тогтолцоо

Дараах хоёр арга хэмжээг нэг дор авах шаардлагатай.

- a. Барилгын хог хаягдал байнга хаядаг нийтийн эзэмшил газрыг хянах арга хэмжээ.
- b. Барилгын хог хаягдал гаргах газрыг хянах арга хэмжээ.

b.1 Нийтийн эзэмшил газрыг хянах тогтолцоо байгуулах

- a. Дүүрэг нь нийтийн эзэмшил газрыг хоггүй цэвэрхэн байлгах үүрэгтэй.
- b. Хувь этгээд нийтийн эзэмшил газрыг хувийн зорилгоор ашиглах зөвшөөрлийг дүүргээс авах шаардлагатай бөгөөд тэрхүү зөвшөөрлийг тухайн ашиглаж буй газар дээр олон нийтэд үзүүлж байх ёстой. Дүүрэг нь барьцаа мөнгө авч нийтийн эзэмшил газар ашиглах хүсэлт гаргасан этгээдээс түрээсийн мөнгө авна.

b.2 Орон сууцны засварын ажлыг хянах тогтолцоог байгуулах


- a. Орон сууцны засварын ажил хийлгэх захиалагч этгээд нь барилгын хог хаягдлыг дарж булах зардлыг нөхөхүйц тодорхой хэмжээний барьцаа төлбөрийн хамт дүүрэгт засварын ажил хийх тухай хүсэлт гаргана. Захиалагч нь тэрхүү зөвшөөрлийн бичгийг хаалган дээрээ тавих шаардлагатай. Хэрэв аливаа зөвшөөрөл аваагүй байгаа тохиолдолд дүүрэг нь байрны эзнийг торгоно. Засварын ажил хийх зөвшөөрөл авсан эсэх дээр СӨХ-ийн зүгээс дүүргүүдэд тусламж дэмжлэг болх үүрэгтэй.
- b. Барьцаа төлбөрийг дүүргийн барилгын хог хаягдлын үйлчилгээний сан дээр түр байршуулна.
- c. Барилгын засварын ажил дууссаны дараа захиалагч этгээд барилгын хог хаягдлаа холбогдох дүрэм журмын дагуу хаясан тухай баримт материалыг дүүрэгт үзүүлэх шаардлагатай. Хэрэв гүйцэтгэгч нь хогоо ТҮК-тай гэрээ байгуулан хогоо зайлуулсан тохиолдолд төлбөрийн баримтыг дүүрэгт үзүүлж болно. Хэрэв гүйцэтгэгч нь хогоо хогийн төвлөрсөн цэг рүү тээвэрлэсэн тохиолдолд Нөөцийн төлбөрийн баримтыг үзүүлж болно.
- d. Хэрэв тэрхүү баримтуудыг дүүрэгт хүргүүлсэн тохиолдолд дүүргийн зүгээс захиалагч этгээдэд барьцаа мөнгийг эргүүлэн өгч болно.
- e. Хэрэв захиалагч нь дүүрэгт тэрхүү баримт материалыг хүргүүлээгүй тохиолдолд дүүрэг нь барьцаа мөнгийг барилгын хог хаягдлын үйлчилгээний санд оруулж хууль бус хог хаягдлыг цэвэрлэхэд зориулна.
- f. Дээрх тохиолдолд барилга засварын ажил гүйцэтгэгч нь дэндүү жижиг хэмжээний ААН, хувь хүн, байнгын үйл ажиллагаа явуулдаг газартай байдаггүй, тэдгээрийг тодорхойлоход хүндрэлтэй байдаг тул гүйцэтгэгч бус захиалагч нь хариуцах шаардлагатай

c. Хувийн хэвшлийн оролцоо

Хатуу хог хаягдлын менежментийн зорилго нь хамгийн бага зардлаар эрүүл ахуй болон байгаль орчныг хамгаалахад оршино. Хувийн хэвшлийн зорилго нь ашигаа

нэмэгдүүлэхэд оршино. Иймд захиалагч тал нь хувийн хэвшлийг ашиглаж хатуу хог хаягдлын менежментийн зорилгод хүрэхэд нэлээд хүндрэлтэй.

Судалгааны багийн зүгээс ТҮК нь дүүргийн хэлтэс эсвэл дүүргийн эсвэл хотын өмчийн компани байж улмаар хувийн хэвшил нь ТҮК-ийн доор хатуу хог хаягдлын менежментэд оролцдог байх нь зүйтэй гэж зөвлөмж болгож байна.



d. Гэрээний нөхцөл шаардлагууд

Нийтийн тендер эсвэл хэлэлцээний үндсэн дээр сонирхол бүхий холбогдох талуудын хооронд гэрээний үнийн дүнг тогтооно. Үйлчилгээ үзүүлэх байгууллагад тодорхой хэмжээний ашигтай байх бөгөөд байнгын сайн чанарын үйлчилгээ авах шаардлагыг харгалзан гэрээнийн байж болох суурь үнийн дүнг дараах байдлаар санал болгож байна.

e. Гэрээний менежментийн тогтолцоо

e.1 Тендер

Тендер нь нээлттэй эсвэл тусгай өрсөлдөөнт хэлбэртэй байж болно. Нээлттэй тендерийн үед УБ хотын захиргаа нь нийтэд тэрхүү тендерийг зарлах бол тусгай өрсөлдөөнт тендерийн үед тендерийг ерөнхийдөө зөвхөн хотын захиргаанд бүртгэлтэй гүйцэтгэгч нарын дунд зарлах болно.

Тендерийн процедур

Ихэнх тохиолдолд хог хаягдал цуглуулж тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх гэрээ нь тендерийн үр дүн байдаг. Захиргааны болон техникийн нөхцлүүдийг тендерийн процедурын явцад тохирдог. Дараах хүснэгтээр тендерийн процедурын явцад анхаарах шаардлагатай асуудлуудыг тусгав. Тендерийн процедурын эрх зүйн баталгааг хангахын тулд тендерийн нийт процедурын үйл ажиллагааг хуулийн зөвлөх этгээдээр хянуулах шаардлагатай.

Хүснэгт 7-17: хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх ажлын тендерийн
процедурын явц

Үйл ажиллагаа	Нарийвчилсан тайлбар
Үнэлгээ	Хог хаягдал цуглуулах үйлчилгээ үзүүлэх ажлын тендерийн материалыг бэлтгэхийн өмнө үйлчилгээний өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагатай. Жишээлбэл: үйлчилгээний хамрах хүрээ / үйлчлэх хүн ам, цуглуулах давтамж, машин техникийн онцлог байдал, цуглуулан тээвэрлэх хог хаягдлын хэмжээ, хог хаягдлын онцлог зэрэг болно.
Шийдвэр гаргах	Өнөөгийн өнхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөхийн сацуу үйлчилгээ нөхцөл болон түүний чанарыг тодорхойлж шийдвэрлэх шаардлагатай. Үнэлгээний явцад тухайн нэг үйл ажиллагааг хувийн хэвшлээр хийлгэх эсэх тухай дүн шинжилгээг хийж харгалзан үзэх шаардлагатай.
Үйлчилгээний зардлыг тооцох	Үйлчилгээний ажлыг гүйцэтгэх гэсэн саналд үнэлгээ хийлгэх зорилгоор тендер явуулах үйлчилгээний зардлыг харгалзах шаардлагатай. УБ хотын захиргаа нь тухайн нэг үйлчилгээний зардлыг гаргах боломжтой эсэхийг мөн харгалзан үзэх шаардлагатай. Хэрэв боломжгүй тохиолдолд үйлчилгээний нөхцөл, чанарын асуудлыг эргэн харж үйлчилгээний чанарын тогтвортой байдлыг хангах зорилгоор төсвийн хөрөнгийн хэмжээнд тохируулан үнийн дүнд өөрчлөлт оруулах хэрэгтэй.
Захиргааны болон техникийн баримт бичгийн боловсруулалт	Үйлчилгээний онцлог байдлын талаар нэгэнт шийдвэр гаргасан тохиолдолд захиргааны болон техникийн баримт бичгийг боловсруулах шаардлагатай. Улаанбаатар хотын захиргаа нь шууд утгатай, тохируулсан захиргааны баримт бичиг боловсруулах нь найдвартай компани сонгох механизмыг бүрдүүлж өгнө. Захиргааны баримт бичиг нь тухайн компанийн эрх зүйн, эдийн засгийн болон техникийн нөхцлүүдийг тодорхойлох шаардлагатай. Нөгөөтэйгүүр, хууль эрх зүйн хүрээ болон хамрагдах шүүхийн байгууллага, гэрээний хүчинтэй байх хугацаа, саналд үнэлгээ өгөх механизм, тасалбар, баталгаа, ажилд авах процедур зэргийг тодорхойлно. Техникийн баримт бичигт хогны машин, төхөөрөмжийн төрөл, марк, техникийн нарийвчилсан үзүүлэлтүүд, үйл ажилаагааны нарийвчилсан төлөвлөгөө, компанийн бүтэц зохион байгуулалт, захиргааны бүтэц, үйлчилгээ болон эрсдлээс сэргийлэх хөтөлбөр, төсөв болон иргэд оршин суугчидтай харьцах төлөвлөгөө зэрэг асуудлууд орно.
Хяналтын тогтолцоог байгуулах	Тендер хийх шаардлагатай ажил үйлчилгээний онцлог байдлыг харгалзан техникийн болон захиргааны асуудлуудыг оролцуулан гэрээг хянах хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай.
Үйлчилгээ үзүүлэх ажлын тендер	Тендерийн бэлтгэл ажил дууссан тохиолдолд тендерийн процесс эхлэх бөгөөд дараах үйл ажиллагааг хамруулна. Үүнд: компаниудыг урих эсвэл өрсөлдөөн зарлах, суурь мэдээллийг түгээх, санал хүлээн авч нээх, саналын үнэлгээ хийх, ялах, гэрээнд гарын үсэг зурах, үйлчилгээгээ тохирч түүхнийг хэрэгжүүлэх.

е.2 Тендерийн баримт бичиг

Тендерт шаардагдах хамгийн наад захын баримт бичгүүд. Үүнд:

Захиргааны баримт бичиг

Ерөнхий асуудлууд

- Тендерийн зорилго,
- Хамрагдах эрх зүйн нормативын тухай тайбар
- Урьдчилсан нөхцлүүдийг хүлээн зөвшөөрөх байдал
- Тухайн газар нутаг эсвэл төслийн тухай ойлголт
- Тендерийн баримт бичиг хүлээн авах ба зөвлөгөө (нээлттэй тендер)
- Гэрээний хүчинтэй байх хугацаа
- Төсөв
- Тендерийн баримт бичиг боловсруулахад шаардагдах асуулт, хариултын тайлбар
- Эрх зүйн хамаарал болон албан ёсны хаяг

Саналын бүтэц

- Тендерт оролцогч тал тендерийн процесс дуустал оролцох шаардлага
- Тендерт оролцогчийн туршлага, хөрөнгө болон санхүүгийн байдлыг тодорхойлох баримт бичиг
- Тендерийн бонд

- Санал тавьж буй хугацаа
- Саналын үнэн зөв болон хангалттай байдал
- Санал тавих арга зам

Ялах процесс

- Санал нээх процесс
- Саналын дүн шинжилгээ болон үнэлгээний процедур
- Ялах процедур
- Гэрээнд гарын үсэг зурах
- Гэрээний баталгаа
- Буулт хийх, шилжүүлэх, холбогдох, дараагийн шатны гэрээ хийх

Гэрээний гүйцэтгэл

- Гэрээг зохицуулах баримт бичиг
- Ажлыг эхлүүлж гүйцэтгэх
- Ажлыг нэмэгдүүлэх эсвэл багасгах
- Арга хэмжээ авах болон торгох
- Арга хэмжээ авах болон торгохын эсрэг гомдол гаргах процедур
- Техникийн болон захиргааны хариуцлага
- Даатгал, баталгаа
- Үйлчилгээний төлбөр, дахин тохируулах, гэрээг нэмэгдүүлэх
- Татвар, ханш, хандив

Гэрээ дуусгавар болох

- Цуцлах, түдгэлзүүлэх, гэрээг хүлээлгэн өгөх

Техникийн асуудлууд

Ерөнхий асуудлууд

- Үйлчилгээний тухай тайлбар
- Суурь мэдээлэл ашигласан нэр томъёоны тайлбар
- Гэрээнд хамрагдах хог хаягдлын тухай тайлбар
- Сард цуглуулах хог хаягдлын хамгийн доод хэмжээ.

Техникийн асуудлууд

- Үйлчилгээний бүс ба салбар:
 - үйлчилгээнд хамрагдах нийт бүсийн хязгаар ба салбар
 - хүн ам, өрх, байгууллага зэрэг хог хаягдал гаргагчийн тухай мэдээллийн бааз.
 - хог хаягдлын бүтэц
 - сард хийх рейсийн тоо болон цуглуулах тонн
 - хог хаягдлын очих газар
 - цуглуулсан хог хаягдлын өмч
- Үйлчилгээний арга барил
- Давтамж, цагийн хуваарь, ажиллах өдрүүд
- өдөр тутмын ажлын хуваарь
- үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг болох ажлыг хэрхэн зохион байгуулах болон хөгжүүлэх тухай тайлбар
- тендерт оролцогч нь саналдаа оруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний хамгийн наад захын шаардлага
- тоног төхөөрөмж, тодорхойлолт, шаардлага, үйлдвэр ба нөөцийн тоо, ашигтай байдал г.м.
- байгууламжуудын тайлбар (засварын цех, контор, г.м.)
- ажилчдын томилгоо
 - машин бүрт ногдох жолооч болон ачигчдын тоо,

- нөөцийн ажилчид
- цалин,
- сургалтын төлөвлөгөө,
- хөдөлмөр хамгаалал,
- үйлчилгээний хяналтын тогтолцоо, г.м.
- Хэрэгжүүлэх процедур ба үйлчилгээг эхлүүлэх
- Бүртгэлийн тогтолцоо ба тайлан

Техникийн саналын баримт бичиг

- Техникийн саналын нарийвчилсан тайлбар

Хавсралт

- Саналыг үнэлэхэд шаардлагатай төлөвлөгөө болон бусад шаардагдах мэдээллийг хүргүүлсэн байх ёстой.

Тендерт ялсан тохиолдолд тендерийн баримт бичиг (захиргааны болон техникийн), асуулт хариулт болон санал болгосон үнийн дүн зэрэг нь гэрээний салшгүй нэг хэсэг болдог.

е.3 Гэрээний аудит

Гэрээнд гарын үсэг зурснаас хойш дүүрэг нь гэрээний хэрэгжилт дээр хяналт тавина. Үйл ажиллагаа, хяналтын нэгж нь үйлчилгээний хэрэгжилтийг хянах ба үнэлгээ өгөх, гэрээний заалтыг зөрчиж байгаа тухай баримт цуглуулах тогтолцоо бий болгох, үйлчилгээтэй холбоотой сарын тайлан бичих зэрэг асуудлуудыг хариуцаж улмаар тэрхүү ажлуудын үндсэн дээр дүүрэг нь зохих төлбөрийг хийх, шаардлагатай бол торгууль ногдуулах зэрэг арга хэмжээг авна.

f. Нэгдсэн гэрээ

Улаанбаатар хотын захиргааны зүгээс санал болгосон зохион байгуулах төлөвлөгөөний хэрэгжилтийн дагуу дүүрэг нь хог хаягдлын менежменттэй холбоотой бүх ажлуудыг санхүүжүүлэх, зөвхөн ТҮК нь төлөвлөгөөт бүсэд ажлыг гүйцэтгэх, ТҮК эсвэл хувийн компани төлөвлөгдөөгүй бүсэд ажлыг гүйцэтгэх асуудлуудыг тус тус хариуцаж байна. Хэрэв гэрээний хоёр тал ижилхэн бол гэрээг нэгтгэж болно. Хог хаягдал цуглуулах ба тээвэрлэх нэгдсэн гэрээний хүрээнд хамруулж болох хог хаягдлын саналыг Хүснэгт 7-18-т үзүүлэв.

Хүснэгт 7-18: Нэгдсэн гэрээнд хамруулж болох хог хаягдал

Хог хаягдлын төрөл	Тайлбар	Нэгдсэн гэрээ тохирох эсэх
Орон сууцны хог хаягдал	Жилийн турш гарах тооцоолсон хог хаягдлын хэмжээ хэлбэлзэх нь маш бага.	Нэгдсэн гэрээ
Зам талбайн цэвэрлэгээ	Жилийн турш гарах тооцоолсон хог хаягдлын хэмжээ хэлбэлзэх нь маш бага.	Нэгдсэн гэрээ
ААН-ийн хог хаягдал (үл хөдлөх хог хаях этгээд /тогтмол нэг газар үйл ажиллагаа явуулах байгууллага) Жишээлбэл: з/б, ресторан, албан контор, дэлгүүр, үйлдвэрийн газар	Жилийн турш гарах тооцоолсон хог хаягдлын хэмжээ хэлбэлзэх нь өндөр байж болзошгүй.	Нэгдсэн гэрээнд хамруулах боломжтой боловч хог гаргагч нарын жагсаалтыг байнга хянаж шинэчилж байх шаардлагатай.
ААН-ийн хог хаягдал (үйл ажиллагаа явуулах газраа байнга өөрчилдөг этгээд) Жишээлбэл: барилгын хог хаягдал	Хог хаягдлын хэмжээг тооцоолох хүндрэлтэй	Тусдаа гэрээ
Түр хугацаатай бий болох олон нийтийн хог хаягдал Жишээлбэл: Наадам, бусад арга хэмжээний хог хаягдал	Хог хаягдлын хэмжээг тооцоолох хүндрэлтэй байж болзошгүй	Тусдаа гэрээ
Түр хугацаатай бий болох хувийн этгээдийн хог хаягдал Жишээлбэл: Овор ихтэй хог хаягдал, их хэмжээний хог хаягдал	Хог хаягдлын хэмжээг тооцоолох маш хүндрэлтэй	Тусдаа гэрээ

Энэхүү саналын дагуу ажлын хүрээг тодорхойлох зорилгоор нэгдсэн гэрээ нь дараах мэдээллийг агуулсан байх шаардлагатай. Үүнд:

- a) Хил хязгаар
- b) Хамрагдах хүн ам ба өрхийн тоо.
- c) Хамрагдах ААН-ийн жагсаалт.
- d) Хамрагдах парк болон ногоон байгууламжуудын жагсаалт.
- e) Хамрагдах замын жагсаалт.

ААН-ийн хог хаягдал (үйл ажиллагаа явуулах газраа байнга өөрчилдөг этгээд) жишээлбэл: барилгын хог хаягдал, түр бий болох нийтийн хог хаягдал, жишээлбэл: Наадам, бусад арга хэмжээний хог хаягдал, түр хугацаатай бий болох хувийн этгээдийн хог хаягдал, жишээлбэл: тавилга зэрэг хог хаягдал цуглуулж тээвэрлэх үйлчилгээний гэрээг тусад нь хийх шаардлагатай бөгөөд дүүрэг болон ТҮК-ийн хооронд гэрээ байгуулна.

7.8.4 Чадавхийг сайжруулах

Судалгааны явцад Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын асуудал хариуцах ажилтан нарын чадавхи эрс сайжирсан боловч Улаанбаатар хотод байгаль орчинд халгүй хатуу хог хаягдлын менежментийн тогтолцоо байгуулахад хангалтгүй байсаар байна. Ялангуяа, дараах асуудлуудаар хангалтгүй байна. Үүнд:

- Хог хаях журам боловсруулж бэлтгэх, гүйцэтгэх, тарааж түгээх
- Ангиан цуглуулах ажлыг төлөвлөх, бэлтгэх, гүйцэтгэх, тарааж түгээх
- Ялгах цех, RDF үйлдвэрлэлийн байгууламжийн ажлын төлөвлөгөө гаргах, бэлтгэх, үйл ажиллагааг хангах
- Эрүүл ахуйн шаардлага хангах ландфилын төлөвлөгөө гаргах, бэлтгэх, үйл ажиллагааг хангах
- Аюултай хог хаягдлыг боловсруулах, дарж булах байгууламжийн төлөвлөгөө гаргах, бэлтгэх, үйл ажиллагааг хангах

Судалгааны багийн зүгээс чадавхийг сайжруулах дээрх асуудлуудаар гадаадын техникийн ажиллагааны хүрээнд хамтран хэрэгжүүлэхийг Улаанбаатар хотын захиргаа болон бусад холбогдох байгууллагуудын хамт хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

8. Чадавхийг хөгжүүлэх

8 Чадавхийг хөгжүүлэх

8.1 Чадавхийг хөгжүүлэх аргачлал

“Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн холбогдолтой институт, зохион байгуулалт болон хүний нөөцийн чадавхийг сайжруулах” гэсэн энэхүү судалгааны зорилгод хүрэхийн тулд удиртгал тайланг хэлэлцэх явцад төслийн Монголын талын хамтрагч байгууллага болон судалгааны баг хамтран 1.3.2 дугаар хэсэгт дурьдсан судалгааг хэрэгжүүлэх бүтцийг бий болгосон билээ.


Улаанбаатар хотын холбогдох талуудын чадавхийг хөгжүүлэхийн тулд дараах зургийн дагуу бий болгосон тогтолцоог судалгааны баг санал болгосон.

а. Техникийн ажлын хэсэгтэй хамтран долоо хоног тутмын уулзалтууд

Төслийн Удирдах зөвлөл техникийн ажлын хэсгийн байгуулж 21 гишүүнийг томилсон. 2004 оны 12 дугаар сараас 2006 оны 12 дугаар сарын эцэс хүртэл нийт 62 долоо хоногийн уулзалтуудыг зохион байгуулав. Уулзалтанд ихэвчлэн техникийн ажлын хэсгийн байнгын гишүүд оролцож байв. Тухайн уулзалтаар ярилцах сэдвээс хамаарч байнгын бус гишүүдийг урьж оролцуулав. Уулзалтын зорилго нь PLA (тухайн арга хэмжээнд оролцох хэлбэрээр суралцаж шийдвэр гаргах) аргыг ашиглан хатуу хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оршиж байв. Уулзалт бүр хоёроос гурван цагийн хугацаанд үргэлжилж дараах асуудлуудыг ярианы гол сэдвүүд болж байв. Үүнд:

- Судалгааны явц ба гарч буй хүндрэлүүд, шийдвэрлэх арга зам;
- Дараагийн долоо хоног бүрийн ажлын хуваарь ба агуулга,
- Боломжит газрыг сонгох, хог хаягдлын хэмжээ, бүтцийн судалгаан дээр үндэслэн хог хаягдлын урсгалыг тогтоох аргачлал, Мастер төлөвлөгөөний хувилбарууд зэрэг хатуу хог хаягдлын менежментийн төлөвлөлт хийхэд шаардагдах тодорхой асуудлууд.

Долоо хоног бүрийн уулзалтууд нь судалгааны ажлын хэрэгжилтийг аливаа хүндрэл бэрхшээлгүй явуулахын зэрэгцээ судалгааны үндсэн гишүүд хатуу хог хаягдлын Мастер төлөвлөгөө хэрхэн боловсруулах талаар ойлголттой болох улмаар хувь хүн бүрийн хатуу хог хаягдлын менежментийн асуудлаар чадавхийг дээшлүүлэх боломжийг нь олгов. Техникийн ажлын хэсгийн уулзалтуудын сэдвүүдийг энэхүү тайлангийн Мэдээлэл, материалын түүвэр хэсэгт оруулсан болно.



Зураг 8-1: Судалгааны явц дахь чадавхийг хөгжүүлэх тогтолцоо

b. Удирдах зөвлөлийн уулзалтууд

Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментэд олон байгууллагууд оролцох бөгөөд байгууллага хоорондын зөрчил гарах нь дамжиггүй юм. Иймд салбарын хүрээнд гарч болзошгүй зөрчилыг шийдвэрлэх, талуудын дунд зөвшилцөл бий болгож бодлогын түвшинд шийдвэр гаргахад Удирдах зөвлөлийн уулзалтын зорилго оршиж байв.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд Удирдах зөвлөл таван удаа хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

- Удиртгал тайланг хэлэлцэж батлах;
- Төвийн зургаан дүүргийн ирээдүйн хогийн төвлөрсөн цэгийг сонгох зурган боломжит хувилбаруудыг танилцуулах болон 2005 оны 1 дүгээр сарын Байгаль орчны сайдын тушаалын дагуу хаагдахаар төлөвлөгдөж байсан Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг яаралтай сайжруулах туршилтын төслийн хэрэгжилтийг батлуулах;
- Төвийн зургаан дүүргийн ирээдүйн хогийн төвлөрсөн цэгээр Нарангийн энгэрийг сонгох шийдвэр гаргах;
- Дунд шатны тайлан болон Мастер төлөвлөгөөнд баримтлах бодлогын талаар хэлэлцэж ТЭЗҮ хийх шаардлагатай тэргүүн зэрэглэлийн төслүүд болон туршилтын төслүүдийн талаар шийдвэр гаргах;
- Судалгааны 3 дугаар үе шатыг хэрэгжүүлэх шийдвэр гаргах.

c. Туршилтын төслүүдийн ажлын хэсгүүд

Дараагийн бүлэгт дурьдсаны дагуу энэхүү судалгааны явцад хэд хэдэн туршилтын төслүүдийг хэрэгжүүлсэн бөгөөд төслийн Монголын талын хамтрагч байгууллага тэдгээрийг гүйцэтгэх санаачлагыг авч хэрэгжүүлэв.

Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг яаралтай сайжруулах болон хог хаягдлын асуудлаар иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх туршилтын төслийг хэрэгжүүлэхэд хамтрагч байгууллага, техникийн ажлын хэсэг, ТББ, оршин суугчдаас нар бүрдсэн ажлын хэсгийг байгуулсан билээ. Нарийвчилсан ажлын хуваарь, холбогдох байгууллагуудын үүрэг роль, хянах аргачлал, төслүүдийн үнэлгээ болон төсөл хэрэгжүүлэх арга барилын талаар тайлбарлав.

Туршилтын төсөл бүр дээр ажлын хэсэг гэдэг бүтцийг бий болгож нарийвчилсан ажлын хуваарь, холбогдох байгууллагуудын үүрэг роль, хянах аргачлал, төслүүдийн үнэлгээ болон төсөл хэрэгжүүлэх арга барилын талаар ярилцах болно. Төслийн Монголын талын хамтрагч байгууллагын нэг гишүүн нь ажлын хэсэгт орж удирдлагаар хангаж ажиллав. Ажлын хэсэг нь Монголын талын хамтрагч байгууллага, техникийн ажлын хэсэг, ТББ, төсөл хэрэгжих нутгийн оршин суугчдаас бүрдэнэ.

d. Бага хурал

Бага хурал зохион байгуулах гол зорилго бол хог хаягдлын менежментийг сайжруулах асуудал хариуцсан ажилтан нар болон бусад энэхүү асуудлаар сонирхол бүхий талуудын дунд зөвшилцөл, нэгдсэн ойлголттой болоход оршино. Дараах 4 бага хурлыг зохион байгуулсан. Бага хурлын үйл ажиллагаанд техникийн ажлын хэсгийн гишүүд, төрийн бус байгууллагуудын төлөөлөгч нар, туршилтын төслийн орчимд амьдарч буй иргэд болон төсөл гүйцэтгэгч нар оролцов.

Монголын талын хамтрагч байгууллага нь хурлын ярилцах асуудлуудын талаар тайлбарлаж илтгэл тавих, асуулт хариултын цагаар оролцогч нарын асуултанд хариулж

байсан бол судалгааны бага хурлын зохион байгуулалт, зохицуулалтыг гүйцэтгэж байв. Хамтрагч байгууллагын зүгээс долоо хоног бүрийн ажлын хэсгийн уулзалтын идэвхтэй оролцоо нь бага хурлын илтгэлүүдийг амжилттай тавихад гол хувь нэмэр болсон.

Хүснэгт 8-1: Бага хурлын тухай

Бага хурал	Он, сар, өдөр	Зорилго	Оролцогч нарын тоо
Анхны	2004.12.9-10	<ul style="list-style-type: none"> Туршлага болон хүндрэл бэрхшээлүүдийн талаар санал бодлоо хуваалцах; Тухайн салбарын талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх ба бусад салбарын асуудлуудтай холбох; Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах талаар нэгдсэн ойлголт, зөвшилцөл бий болгох үйл явцыг эхлүүлэх. 	50 хүн
Хоёрдугаар	2005.04.11	<ul style="list-style-type: none"> Хатуу хог хаягдлын менежментийн мастер төлөвлөгөө боловсруулахад ирээдүйн хогийн төвлөрсөн цэг байгуулах шаардлага, хэрэгцээг ойлгох; Ирээдүйн хогийн төвлөрсөн цэг байгуулах боломжит 6 цэгийг сонгох хатуу хог хаягдлын менежментийн техникийн тогтолцооны хувилбаруудын эерэг ба сөрөг талуудын талаар дүгнэж ярилцах; Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн хүрээнд ирээдүйн хогийн төвлөрсөн цэгийн асуудлаар зөвлөмж гаргах. 	45 хүн
Гуравдугаар	2005.10.18	<ul style="list-style-type: none"> Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг яаралтай сайжруулах болон хог хаягдлын асуудлаар иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх гэсэн хоёр туршилтын төслийг хорооны иргэд болон хог түүгч нараар үнэлгээ хийлгэх 	Хэсэг 1: хорооны иргэд <ul style="list-style-type: none"> • 56 иргэд • 10 ТББ Хэсэг 2: хог түүгч нар <ul style="list-style-type: none"> • 80 хүн
Дөрөвдүгээр	2006.05.17	<ul style="list-style-type: none"> Одоогийн ДЦС дээр RDF түлшийг нүүрстэй хольж шатаахад гарах сөрөг үр дагаварыг судлах Мастер төлөвлөгөөний хүрээнд санал болгох хог хаягдлыг RDF түлш болгон дулааны эрчим хүч үйлдвэрлэх асуудлаар холбогдох талуудын дунд нэгдсэн ойлголттой болохын тулд Улаанбаатар хотын иргэдэд RDF түлшийг нүүрстэй хольж шатаахад гарах эерэг болон сөрөг үр дагаварын талаар үзүүлэх Одоогоор үйл ажиллагаагаа явуулж буй дулааны ба/эсвэл цахилгаан станц дээр RDF түлш ашиглах эдийн засгийн үндэслэл тооцоог хийж судлах 	100 орчим оролцогсод

е. Семинар

Семинарын зорилго нь олон нийтэд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тухай талбарлаж судалгааны бүсийн хүрээнд холбогдох талуудын дунд нэгдсэн ойлголт, зөвшилцөл бий болгоход оршино. Гурван семинарыг дараах хүснэгтэд дурьдсан зорилготойгоор зохион байгуулав. Семинарын үйл ажиллагаанд техникийн ажлын хэсгийн гишүүд, төрийн бус байгууллагуудын төлөөлөгч нар, туршилтын төслийн орчимд амьдарч буй иргэд болон хэвлэл мэдээллийн төлөөлөгч нар оролцов.

Монгол талын хамтрагч байгууллага нь семинарын үер ярилцах асуудлуудын талаар тайлбарлаж илтгэл тавих, асуулт хариултын цагаар оролцогч нарын асуултанд хариулж байсан бол судалгааны баг семинарын зохион байгуулалт, зохицуулалтыг гүйцэтгэж байв. Хамтрагч байгууллагын зүгээс долоо хоног бүрийн ажлын хэсгийн уулзалтын идэвхтэй оролцоо нь семинарын илтгэлүүдийг амжилттай тавихад гол хувь нэмэр болсон.

Хүснэгт 8-2: Семинарын тухай

Семинар	Он, сар, өдөр	Зорилго	Оролцогч нарын тоо
Анхны	2005.4.26	<ul style="list-style-type: none">Холбогдох бүхий л талуудын дунд нэгдсэн ойлголт, зөвшилцөл бий болгох зорилгоор ирээдүйн хогийн төвлөрсөн цэгийн талаар гарсан шийдвэрийг танилцуулах.	61 хүн
Хоёрдугаар	2005.7.6	<ul style="list-style-type: none">Холбогдох бүхий л талуудын дунд нэгдсэн ойлголт, зөвшилцөл бий болгох зорилгоор Мастер төлөвлөгөөний санал болон туршилтын төслүүдийг танилцуулах;Холбогдох бүхий л талуудаас идэвхтэй хамтран ажиллахыг хүсэж туршилтын төслүүдийг тайлбарлах.	75 хүн
Гуравдугаар	2007.1.5	<ul style="list-style-type: none">Судалгааны дүгнэлт, үр дүнг холбогдох талуудад нийтлэх;Мастер төлөвлөгөө хэрэгжүүлэх зорилгоор судалгааны хүрээнд хуримтлуулсан мэдлэг туршлагыг хуваалцахМастер төлөвлөгөөг саад бэрхшээлгүй хэрэгжүүлэх зорилгоор холбогдох талуудтай санал солилцох.	123 хүн

f. Ирээдүйн хогийн төвлөрсөн цэгийн сонгох

Төвийн зургаан дүүргийн ирээдүйн хогийн төвлөрсөн цэгийг сонгоход зургаан боломжит газруудыг хооронд нь байгаль орчин болон эдийн засгийн харьцуулалт хийх судалгаанаас бусад ажлыг ихэвчлэн Монголын тал гүйцэтгэсэн.

g. Тэргүүн зэрэглэлийн төслүүдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ болон төслүүдийг олон нийтэд танилцуулах уулзалтуудыг зохион байгуулах

Хатуу хог хаягдлын хогийн төвлөрсөн цэг болон хог хаягдлыг дахин боловсруулах цогцолбор нь хүрээлэн буй орчин ихээхэн нөлөөлөл үзүүлж болзошгүй. Нарангийн энгэр дэхь хогийн төвлөрсөн цэг (НЭХЦ) болон хог хаягдлыг дахин боловсруулах цогцолбор (НЭРЦ) байгуулахад байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сөрөг нөлөөлөлийг бууруулах, холбогдох талуудын дунд зөвшилцөл бий болгох зорилгоор Улаанбаатар хотын захиргаа Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийсэн. Орон нутгийн иргэд, засаг захиргаа нь одоогийн Улаанчулуутын хогийн цэг сөрөг үр дагавар учруулдаг байсан учир шинэ хогийн цэг болон хог хаягдлыг дахин боловсруулах цогцолбор байгуулах асуудлаар нэлээд сэтгэл зовниж байсан тул төсөл хариуцагч буюу Улаанбаатар хотын захиргаа нь орон нутгийн иргэд, засаг захиргаа болон ТББ-ын төлөөлөгч зэрэг холбогдох бүх талуудыг оролцуулсан шинэ төслүүдийн тухай олон нийтэд танилцуулах гурван уулзалтыг зохион байгуулав.

Монгол талын хамтрагч байгууллага болон тэдний гүйцэтгэгч зөвлөх компани нь уулзалтын үер ярилцах асуудлуудыг тайлбарлаж илтгэл тавих, асуулт хариултын цагаар оролцогч нарын асуултанд хариулж байсан бол судалгааны баг шаардагдах зөвлөмж зөвлөгөө өгч байв. Хамтрагч байгууллагын зүгээс долоо хоног бүрийн ажлын хэсгийн уулзалтын идэвхтэй оролцоо нь уулзалтын илтгэлүүдийг амжилттай тавихад гол хувь нэмэр болсон. Түүнчлэн Япон Улсад зохиогдсон сургалтын үер Хамтрагч байгууллагын хуримтлуулсан туршлага мэдлэг нь хог хаягдлыг дахин боловсруулах цогцолбор болон RDF түлшний үйлдвэрлэл, ашиглалтын талаар гарч байсан оролцогч нарын асуултуудад хариулахад нэлээд хувь нэмэрээ өгөв.

Хүснэгт 8-3: Төслүүдийг олон нийтэд танилцуулах уулзалтуудын тухай

Уулзалт	Он, сар, өдөр	Зорилго	Оролцогч нарын тоо
Анхны	2005.4.26	<ul style="list-style-type: none">Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний төлөвлөгөө болон Нарангийн энгэрт шинэ хогийн төвлөрсөн цэг байгуулах болон хог хаягдлыг дахин боловсруулах цогцолбор байгуулах төлөвлөгөөнд холбогдох бүхий л талуудын санал бодлыг тусгах.	111 хүн
Хоёрдугаар	2005.10.18	<ul style="list-style-type: none">Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дүн, хогийн цэг байгуулах төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулах арга хэмжээг тайлбарлах;Орон нутгийн иргэд болон ТББ-ын төлөөлөгч зэрэг холбогдох бүх талуудтай дүнгийн талаар ярилцаж санал бодлоо солилцох.	88 хүн
Гуравдугаар	2006.5.10	<ul style="list-style-type: none">Нарангийн энгэрт шинэ хогийн төвлөрсөн цэг байгуулах болон хог хаягдлыг дахин боловсруулах цогцолбор байгуулах төлөвлөгөө болон сөрөг үр дагаварыг бууруулах арга хэмжээний талаар тайлбарлах;Төслүүдийн талаар холбогдох бүхий л талуудын дунд нэгдсэн ойлголт, зөвшилцөл бий болгох.	129 хүн

h. Олон нийттэй харилцах үйл ажиллагаа

Олон нийт, хэвлэл мэдээллийнхэнтэй байнга харилцаж байх нь Монголын талын хамтрагч байгууллага болон Улаанбаатар хотын иргэд хоёрын хооронд нийтлэг болон үнэн зөв мэдээлэлтэй байх чухал юм. Судалгааны үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Монголын талын хамтрагч байгууллагатай хамтран мэдээллийн тойм найман дугаарыг, вэб хуудас, хэвлэл мэдээллийн төлөөлөгч нарт зориулан танилцах аялал зэргийг хийж гүйцэтгэв.

8.2 Чадавхийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих асуудлын агуулга

8.2.1 Чадавхийг хөгжүүлэх агуулга

Чадавхийг хэр зэрэг хөгжүүлэн дэмжиж буй байдлыг яналт хийж үнэлгээ өгөөх зорилгоор дараах хүчин зүйлүүдийг харгалзав.

а. Хатуу хог хаягдлын менежментийн суурь мэдээллийг хүлээн авах, үнэлгээ ба менежмент хийх

Хог хаягдлын гарах хэмжээ, ачиж цуглуулах ажил, хаягдал түхий эдийн талаах зах зээл болон хогийн төвлөрсөн цэг дээр бууж буй хог хаягдлын хэмжээ зэрэг асуудлаар суурь мэдээлэл байхгүй байсан тул өнөөгийн хог хаягдлын менежментийн бэрхшээлүүдийг тодорхойлоход хүндрэлтэй байв. Хээрийн суурь судалгаа хэрхэн хийдэг, цуглуулсан мэдээллийг үнэлэж ашиглах, ач холбогдолыг тодорхойлох чадварыг судалгааны явцад суралцав.

Одоогийн хатуу хог хаягдлын менежментийг сайжруулахын тулд цуглуулсан мэдээллийг боловсруулсан зөв зүйтэй үнэлэх, менежмент хийх нь чухал юм.

б. Хатуу хог хаягдлын менежментийн нөхцөл байдалд тохирох холбогдох техник, технологийн төлөвлөлт хийх

Хатуу хог хаягдлын менежментийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болох хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дундын боловсруулалт хийх, хогийн төвлөрсөн цэг дээр буулгах талаар суурь төлөвлөлт хэрхэн хийдэг талаар ойлголттой болох шаардлагатай. Төлөвлөлт хийж тухайн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах аргачлалыг

одоогийн хогийн цэгийн нөхцөл байдлыг сайжруулах болон хог хаягдлыг ачиж цуглуулах тогтолцоог сайжруулах гэсэн туршилтын төслүүдийг хэрэгжүүлж хэрхэн хатуу хог хаягдлын менежментийг сайжруулж буй явцыг ажиглалт хийж суралцав.

с. Төлөвлөлтийг холбогдох бүхий л талуудыг оролцуулан хийх

Одоогийн хатуу хог хаягдлын менежментийн тогтолцоо нь иргэд, олон нийтийн саналыг Засгийн газрын бодлогын чанартай арга хэмжээнүүдэд хангалттай тусгаж чадаагүй байна. Засгийн газрын байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгжүүдийн хооронд идэвхтэй харилцаа хамтын ажиллагаа, уялдааг бий болгох зорилгоор бүхий л талуудыг оролцуулан төлөвлөлт хийдэг үйл ажиллагааг дэмжих шаардлагатай байв. Жишээлбэл судалгааны ажлын хүрээнд зохиогдож буй элдэв арга хэмжээг ашиглан иргэд, олон нийтийн саналыг авч Засгийн газрын бодлогын баримт бичигт оруулах, одоогийн хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах туршилтын төслүүдийн үйл ажиллагааг ашиглах зэрэг болно.

d. Хамтрагч байгууллагуудын идэвх чармайлтыг дэмжиж тэдгээрийн үйл ажиллагааны нээлттэй байх байдлыг хангах

Гүйцэтгэгч байгууллагууд одоогийн нөхцөл байдлын талаар тайлбар хийх, иргэдээс хог хаягдал гаргасны төлбөр авч байгаа учир ирээдүйн төлөвлөлтийн талаар иргэдэд таниулах үүрэгтэй билээ. Түүнчлэн тэдгээр байгууллагууд нь үйл ажиллагааныхаа нээлттэй байдлыг хангах талаар идэвх санаачлага гаргаж ажиллах шаардлагатай. Гүйцэтгэгч байгууллагуудын төлөвлөгөөний үр ашигтай хийж чадах байдлыг бусдад тайлагнах, үйл ажиллагаагаа таниулах чадварыг олон нийттэй харьцах ажиллагаа өргөжүүлэх эсвэл хурал, зөвлөлгөөн дээр оролцож илтгэл тавих замаар дээшлүүлнэ.

e. Холбогдох байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх

Хатуу хог хаягдлын менежментийг Монгол Улсад хэд хэдэн байгууллага хариуцан гүйцэтгэж байгаа байдал нь тэдгээр байгууллагуудын хоорондын харилцаа холбоо, уялдааг хүндрүүлэх талтай юм. Удирдах зөвлөлийн хуралд оролцох, эсвэл туршилтын төслүүдийн хэрэгжилтэд хамтран ажиллах нь тэдгээр институт, байгууллагуудын хооронд нэгдсэн ойлголттой болох, туршлага хуваалцах боломж олгох юм.

8.2.2 Чадавхийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих асуудлын агуулга

Чадавхийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих асуудлын агуулгыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 8-4: Чадавхийг сайжруулах ажлын хүрээнд дэмжлэг үзүүлэх ба мониторинг хийх

Чадавхийг хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсэг	Дэмжлэгийн агуулга	Мониторинг хийх зүйл
1. Хатуу хог хаягдлын менежментийн суурь мэдээллийг хүлээн авах, үнэлгээ ба менежмент хийх	<ul style="list-style-type: none"> Хэрийн судалгаануудын төлөвлөлт, хэрэгжилт ба үнэлгээ Туршилтын төслүүдийн төлөвлөлт, хэрэгжилт ба үнэлгээ 	<ul style="list-style-type: none"> Хатуу хог хаягдлын менежментийн мэдээллийг хэрхэн цуглуулах талаар ойлголттой болж түүнийг ашиглаж өнөөгийн байдалд дүгнэлт хийх ба илтгэл тавих чадвартай болох. Хог хаягдлын хэмжээ зэрэг суурь мэдээллийг тооцоолох чадвартай байх.
2. Хатуу хог хаягдлын менежментийн нөхцөл байдалд тохирох төлөвлөлт хийх	<ul style="list-style-type: none"> Мастер төлөвлөгөөний хувилбаруудыг тогтоох Мастер төлөвлөгөөг боловсруулах Туршилтын төслүүдийн төлөвлөлт, хэрэгжилт ба үнэлгээ, түүнчлэн туршилтын төслүүдийн хэрэгжилтийн дүн дээр үндэслэн Мастер төлөвлөгөөг шинэчлэн өөрчлөх Техник, эдийн засгийн үндэслэл тооцоог хийх 	<ul style="list-style-type: none"> Төлөвлөлтийн явцад оролцож тухайн төлөвлөгөөний утгыг бусдад илтгэх чадвартай болох Туршилтын төслийн хэрэгжилт болон мастер төлөвлөгөөний төсөл дээр үнэлгээ өгөх ажилд идэвхтэй байх

3. Төлөвлөлтийг холбогдох бүхий л талуудыг оролцуулан хийх	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах үйл ажиллагаа Туршилтын төслүүдийн төлөвлөлт, хэрэгжилт ба үнэлгээ 	<ul style="list-style-type: none"> Олон нийтийн санал бодлыг хүндэтгэж зохистой хариуг өгч байх Туршилтын төслүүдийн хэрэгжилтийн явцад олон нийтийн санал бодлыг тусгах
4. Өөрсдийн идэвх санаачлага ба нээлтэй байдлыг хангах	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах үйл ажиллагаа Семинар, бага хурлын төлөвлөлт, хэрэгжилт ба үнэлгээ 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харьцах ажлын хүрээнд мэдээллийн тойм болон вэб хуудасны агуулгыг санаачлагаараа гаргаж ирэх Уулзалтын сэдэв санал болгох болон тэмдэглэлийг өөрийн санаачлагаар хөтлөх Судалгааны явц болон ярилцаж буй асуудлуудын талаар илтгэл тавих
5. Холбогдох байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх.	<ul style="list-style-type: none"> Семинар, бага хурлын ажиллагаанд оролцох Олон нийттэй харилцах үйл ажиллагаа Туршилтын төслүүдийн төлөвлөлт, хэрэгжилт ба үнэлгээ 	<ul style="list-style-type: none"> Уулзалт, хурал зэргийг ашиглан зөвшилцөл болгох Туршилтын төсөл хэрэгжүүлснээр байгууллага болгон өөрийн үүрэг хариуцлага чухлыг ухааран ойлгох

8.3 Чадавхийг хөгжүүлэх асуудлын үнэлгээ


8.3.1 Хувь хүнийн түвшинд хийх чадавхийг хөгжүүлэх асуудлын үнэлгээ

Дээрх хүснэгтийн дагуу “шууд хамруулах хүрээ”-ний хүмүүсийн чадавхийг хөгжүүлэхэд ач холбогдол бүхий асуудлуудыг сонгож тайлангийн үндсэн хэсэгт дурьдсаны дагуу хяналт тавих зүйлүүдийг тодорхойлов. Улмаар 2006 оны 2 дугаар сарын дундуур судалгааны баг Монголын талын хамтрагч байгууллагад хандаж өөрсдийн чадавхийг үнэлэх зорилгоор асуулга тавьж тэрхүү үнэлгээний дүнг дараах зургаар үзүүлэв. Нарийвчилсан үнэлгээ нь 32 зүйлтэй, А болон В гэсэн хоёр аргачлалтай. А аргачлал нь хувь хүнийн мэдлэг, чадварыг үнэлэх бөгөөд Онц: 4, Сайн: 3, Дунд: 2, Муу: 1 гэсэн тус тус оноо олгох системтэй. В аргачлал нь тодорхой нэг ажлыг мэргэжлийн хүмүүсийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэх чадварыг үнэлэх бөгөөд Аливаа тусламж дэмжлэггүй: 4, мэргэжлийн хүмүүсийн бага зэргийн дэмжлэгтэйгээр: 3, мэргэжлийн хүмүүсийн удирдамжаар: 2, боломжгүй: 1 гэсэн тус тус оноо олгох системтэй.

Хүснэгт 8-5: Чадавхийг хөгжүүлэх ажлын Монголын хамтрагч талын үнэлгээ

Чадавхийг хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсэг		Монголын хамтрагч талын үнэлгээ	
Зүйл анги	Үнэлгээний дэлгэрэнгүй зүйл анги	Судалгааны эхэн үе, 2004 оны 12-р сар	2006 оны 2-р сарын дунд үе
1. Хатуу хог хаягдлын менежментийн суурь мэдээллийг хүлээн авах, үнэлгээ ба менежмент хийх	<p>Үнэлгээ хийх А арга:</p> <p>- Мэдлэгээр: 1. Хатуу хог хаягдлын менежментийн суурь мэдээлэл, 2. Хатуу хог хаягдлын менежментийн суурь мэдээллийг хүлээн авах хээрийн судалгаа, 3. Суурь мэдээллийг ашиглаж, Хатуу хог хаягдлын менежментийн өнөөгийн байдлыг үнэлэх үнэлгээ</p> <p>- Чадавхи: 1. Хээрийн судалгаагаар илтгэл тавих, 2. Суурь мэдээллийг ашиглаж, Хатуу хог хаягдлын менежментийн өнөөгийн байдлыг дүгнэн илтгэл тавих</p> <p>Үнэлгээ хийх Б арга:</p> <p>- Хэрэгжүүлэх чадавхиар: 1. Хатуу хог хаягдлын менежментийн суурь мэдээллийг хүлээн авах хээрийн судалгаа, 2. Суурь мэдээллийг ашиглаж, Хатуу хог хаягдлын менежментийн өнөөгийн байдлыг үнэлэх үнэлгээ, 3. Суурь мэдээллийг ашиглаж, Хатуу хог хаягдлын менежментийн өнөөгийн байдлыг дүгнэн илтгэл тавих</p>	1.88	3.06

<p>2. Хатуу хог хаягдлын менежментийн нөхцөл байдалд тохирох техник, технологийн зураг, төлөвлөлт хийх</p>	<p>Үнэлгээ хийх А арга: - Мэдлэгээр: 1. Ирээдүйн төвлөрсөн хогийн цэг (үүд)-ийг сонгох арга, сонгох ажлын явц, 2. Мастер төлөвлөгөөг (М/Т) боловсруулах, 3. Туршилтын төслүүдийн (Т/Т) төлөвлөлт, хэрэгжилт ба үнэлгээ, 4. Туршилтын төслүүдийн хэрэгжилтийн үр дүн дээр үндэслэн М/Т-г шинэчлэн өөрчлөх, 5. Хийж болохуйц нэн тэргүүний төслүүдийг хэрэгжүүлэх - Чадавхи: 1. Судалгаагаар боловсруулсан төлөвлөгөө болон төлөвлөлтийн аргачлалаар илтгэл тавих Үнэлгээ хийх Б арга: - Хэрэгжүүлэх чадавхиар: 1. Ирээдүйн төвлөрсөн хогийн цэг, эсвэл Хатуу хог хаягдлын менежментийн байгууламжийг сонгох, 2. М/Т-г шинэчлэн өөрчлөх, 3. Хийж болохуйц нэн тэргүүний төслүүдийг хэрэгжүүлэх, 4. Дээр дурьдсан төлөвлөлтөөр илтгэл тавих</p>	<p>1.45</p>	<p>3.70</p>
<p>3. Төлөвлөлтийг холбогдох бүх талуудыг оролцуулан хийх</p>	<p>Үнэлгээ хийх А арга: - Мэдлэгээр: 1. Олон нийттэй харьцах ажлын хүрээнд мэдээллийн тойм сонин, вэб хуудас, төслийн ажлыг олон нийтэд танилцуулах уулзалт, бага хурал, семинаруудыг зохион байгуулах арга замаар Хатуу хог хаягдлын тохиромжтой менежментийг боловсруулах, 2. Олон нийттэй харьцах үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах вэ?, 3. Хэрхэн олон нийтийн санал бодлыг хүндэтгэж, зохистой хариу өгөх вэ?, 4. Олон нийтийн санал бодлыг Мастер төлөвлөгөөнд хэрхэн тусгах вэ? - Чадавхи: 1. Хатуу хог хаягдлын тохиромжтой менежментийг боловсруулахын тулд олон нийттэй харьцах үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар илтгэл тавих</p>	<p>2.20</p>	<p>3.60</p>
<p>4. Идэвх санаачлага болон нээлттэй байдлыг хангах</p>	<p>Үнэлгээ хийх А арга: - Чадавхи: 1. Уулзалтын сэдэв санал болгох болон бага хурал, семинар зэргийн тэмдэглэлийг хөтлөх, 2. Судалгааны явц болон ярилцсан асуудлуудын талаар илтгэл тавих - Хэрэгжүүлэх чадавхиар: 1. Олон нийттэй харьцах үйл ажиллагааг төлөвлөх ажлын хүрээнд семинар, бага хурлуудыг зохион байгуулах, мэдээллийн тойм сонин болон вэб хуудасны агуулгыг гаргах гэх мэт ажлыг санаачлах, 2. Олон нийттэй харьцах үйл ажиллагааг зохион байгуулах, 3. Шаардлагатай тохиолдолд өнөөгийн Хатуу хог хаягдлын менежментийн талаарх асуудлууд, сайжруулах төлөвлөгөө болон сайжруулахад шаардагдах хамтын ажиллагаа зэргийг тайлбарлах, 4. Хатуу хог хаягдлын тохиромжтой менежментийг боловсруулахад холбогдох бүх байгууллагуудын чадамжийг нэмэгдүүлэх</p>	<p>2.38</p>	<p>3.63</p>
<p>5. Холбогдох байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх</p>	<p>Үнэлгээ хийх А арга: - Ойлголтоор: 1. Холбогдох байгууллагуудын түншлэл болон зохицуулалт - Чадавхи: 1. Холбогдох байгууллагууд хурлаар тохиролцоонд хүрэх, 2. Байгууллага болгон үүрэг хариуцлагатай байх</p>	<p>2.58</p>	<p>3.25</p>
<p>Дундаж</p>		<p>2.10</p>	<p>3.45</p>



Зураг 8-2: Чадавхийг хөгжүүлэх асуудлаар Монголын талын хамтрагч байгууллагын өгсөн үнэлгээ

Монголын талын хамтрагч байгууллагын өгсөн үнэлгээний дагуу дараа дүгнэлтийг хийх байна. Үүнд:

- Тэдгээрийн хийсэн үнэлгээний дагуу Монголын талын хамтрагч байгууллагын чадавхи нэлээд сайжирсан байна. Өөрөөр хэлбэл, судалгааны дараа өгсөн үнэлгээгээр дундаж оноо нь 3.45 (Сайн болон Онцын хооронд эсвэл “Мэргэжлийн хүмүүсийн бага зэргийн дэмжлэгтэйгээр” болон “Аливаа тусламж дэмжлэггүй” –ийн хооронд) байсан бол судалгаа хэрэгжихийн өмнө дундаж оноо нь зөвхөн 2.10 (Дунд эсвэл Мэргэжлийн хүмүүсийн удирдамжаар) байв.
- “4.Өөрсдийн идэвхи санаачлага ба нээлтэй байдлыг хангах” болон “5.Холбогдох байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх” гэсэн үнэлгээний асуудлуудаар судалгаа эхлэхийн өмнө ч Монголын талын хамтрагч байгууллагын чадавхи нь өндөр байв.
- Нөгөөтэйгүүр, “1.Хатуу хог хаягдлын менежментийн суурь мэдээллийг хүлээн авах, үнэлгээ ба менежмент хийх” болон “2.Хатуу хог хаягдлын менежментийн нөхцөл байдалд тохирох төлөвлөлт” хийх гэсэн үнэлгээний асуудлуудаар судалгаа эхлэхийн өмнө Монголын талын хамтрагч байгууллагын мэдлэг чдвар бага байв.
- Судалгааны явцад хамгийн сайжирсан асуудал бол “2.Хатуу хог хаягдлын менежментийн нөхцөл байдалд тохирох төлөвлөлт” болон дараагаар нь “1.Хатуу хог хаягдлын менежментийн суурь мэдээллийг хүлээн авах, үнэлгээ ба менежмент хийх” асуудал тус тус дараалан орж байна
- Нөгөөтэйгүүр, хамгийн бага хэмжээгээр сайжирсан асуудал бол “5.Холбогдох байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх” байсан бөгөөд холбогдох байгууллагуудын дунд зохицуулалт хийх, нэгдсэн ойлголтыг бий болгох нь хамгийн хэцүү асуудал болох нь ойлгомжтой байна. Ирээдүйн

хогийн төвлөрсөн цэгийг сонгоход Улаанбаатар хотын захиргаа болон БОЯ хоёрын хооронд зохицуулалт хийхэд хүндрэлтэй байсаны илэрхийлэл болно.

8.3.2 Байгууллага, институт болон нийгмийн түвшний чадавхийг хөгжүүлэх

Судалгааны хэрэгжилтийн хүрээнд хийсэн байгууллага, институт болон нийгмийн түвшний чадавхийг хөгжүүлэх асуудлыг дараах хүснэгтээр хураангуйлав.

Хүснэгт 8-6: Байгууллага, институт болон нийгмийн түвшний чадавхийг хөгжүүлэх үнэлгээ

Түвшин	Байгууллага	Чадавхийг хөгжүүлэх асуудлын агуулга
Байгууллага	Улаанбаатар хотын захиргаа/ХНААХ	<ul style="list-style-type: none"> Хот хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөнд хатуу хог хаягдлын менежментийн Мастер төлөвлөгөөг суулгаж 2005 оны 7 дугаар сарын дундуур хотын дарга Нарангийн энгэрийг хотын төвийн зургаан дүүргийн ирээдүйн хогийн төвлөрсөн цэгийн газрыг баталгаажуулах захирамж гаргав.
	Улаанбаатар хотын захиргаа /ХТХ, 2006 оны 9-р сараас ХТГ	<ul style="list-style-type: none"> Судалгааны зөвлөмжийн дагуу 2006 оны 9 дүгээр сард Хотын захиргаа нь Хот тохижилтын газрыг байгуулав. ХТГ-ын үндсэн 5 ажилтан нь Хот тохижилтын хэлтсээс шилжин ирж УБ хотын хатуу хог хаягдлын менежментийн асуудлыг хариуцаж байна. Шинээр байгуулагдсан газар нь 2006 оны эцсийн байдлаар 25 ажилтанг шинээр ажилд авч хотын төсвөөс санхүүжүүлэн цаашид мөн хотоос санхүүжих 15 нэмж авахаар төлөвлөж байна. ХТГ нь бие даасан өөрийн төсөвтэй, ажилтан нараа томилдог байгууллага байна. Хотын дарга болон нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн дагуу ХТХ нь хатуу хог хаягдлын менежментийн салбарт зориулах хөрөнгийг нэмэгдүүлэв. Ялангуяа, УЧХЦ дээр туршилтын төсөл хэрэгжүүлэх ихээхэн хэмжээний хөрөнгө буюу 67,000 ам.долларыг батлуулсан бөгөөд Нөөц компанийн төсвийг 2005 оны байдлаас 2006 онд тав дахин нэмэгдүүлж чадав. Төвийн зургаан дүүргийн ирээдүйн хогийн төвлөрсөн цэгээр Нарангийн энгэр гэдэг газрыг холбогдох талуудын зөвшилцөл дээр үндэслэн сонгов. НЭХЦ байгуулах байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг БОЯ-аар батлуулав. ХТХ нь НЭХЦ болон НЭРЦ байгуулах төслүүдийн талаар олон нийтэд танилцуулах гурван уулзалтыг зохион байгуулав.
	Улаанбаатар хотын захиргаа /НМХГ	<ul style="list-style-type: none"> УЧХЦ-ийн үйл ажиллагааг хянах хяналтын хороог байгуулсан. НМХГ хогийн төвлөрсөн цэгийн байнгын хяналтыг хийх боломжтой болсон бөгөөд хяналтын үнэлгээний дүнг шаардлага гарвал хэвлэн мэдээлэх боломжтой болов.
	УЧХЦ болон МДХЦ-ийн үйл ажиллагааг хангах Нөөц компани	<ul style="list-style-type: none"> Хогийн төвлөрсөн цэгийн менежментийг найдвартай хангах зорилгоор Нөөц компанийн төсвийг 2005 онтой харьцуулахад 2006 онд тав дахин нэмэгдүүлсэн.
	Эрүүл мэндийн яам (ЭМЯ)	<ul style="list-style-type: none"> Өнөөгийн эмнэлгийн хог хаягдлын (халдвартай/аюултай) менежментийн байдлыг эмнэлгийн хог хаягдлын судалгааны хүрээнд тодорхойлсон. Эмнэлгийн хог хаягдлыг гарах хэмжээ болон хог хаягдлын менежменттэй холбогдох асуудлуудыг тодорхойлов.
	Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ)	<ul style="list-style-type: none"> Барилгын хог хаягдлын хэмжээг судалгааны хүрээнд тодорхойлсон. Барилгын хог хаягдлыг гарах хэмжээ болон хог хаягдлын менежменттэй холбогдох асуудлуудыг тодорхойлов.
Институт болон нийгэм	<ul style="list-style-type: none"> 2005 оны 11 дүгээр сард Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор одоогийн УЧХЦ, МДХУ болон НЭХЦ-ийн хамгаалалтын бүсийг тогтоож гэр хороолол тэлж орох байдлаас сэргийлэх арга хэмжээ авав. Судалгааны санхүүгийн дүн шинжилгээний хүрээнд хогны менежментийн төлбөрийн хэмжээ өөрчлөгдөж 2006 оны 9 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөж эхлэв. 	

		<ul style="list-style-type: none">• Судалгааны зөвлөмжийн дагуу нийслэл болон дүүрэг тус бүрт хог хаягдлын үйлчилгээний санг байгуулж тэдгээрийн үйл ажиллагааг 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлүүлэв. Хог хаягдлын үйлчилгээний сангийн тогтолцоог нэвтрүүлснээр одоогийн хог хаягдал цуглуулах тогтолцооны хогны төлбөр хурах систем болон гэр хороололд хог хаягдал цуглуулах үйлчилгээг нэмэгдүлэх гол хүчин зүйл болох салбар хоорондын татаасын тогтолцоог ажиллах боломжийг олгох юм.• Хог хаягдлын үйлчилгээний сангийн тогтолцоог нэвтрүүлснээр одоогийн хатуу хог хаягдлын менежментийн санхүүгийн тогтолцоог 3.3.8 дугаар хэсгийн 3.12 дугаар зурагт үзүүлсний дагуу эрс сайжруулах болно.• ХТХ/Нөөц компани нь УБ хотын томоохон хогийн цэг дээр ажиллах 300 хог түүгч нарт үнэмлэх олгож тэдгээр хүмүүсийн нийгэмшүүлэх баталгааг гаргав. Түүнчлэн ХТХ /Нөөц компани нь хог түүгч нарыг зохион байгуулалтанд оруулж харилцан бие биенийгээ дэмжих санг байгуулав.
--	--	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

9. Туршилтын төслүүд

9 Туршилтын төслүүд

9.1 Туршилтын төслүүдийн сонголт

9.1.1 Туршилтын төслүүдийн зорилго

Мастер төлөвлөгөөнд тусгасан төслүүдийг хэрэгжүүлэх тохиолдолд тодорхой хүндрэл бэрхшээлтэй тулгарч болзошгүй юм. Тэдгээр хүндрэл бэрхшээлүүдийг тодорхойлох болон хэрхэн шийдвэрлэхийн тулд Монголын талын хамтрагч байгууллага болон бусад холбогдох талуудын хамт судалгааны хэрэгжилтийн явцад туршилтын төслүүдийг гүйцэтгэсэн болно. Туршилтын төслүүдийн зорилгыг дараах байдлаар хураангуйлав.

- Туршилтын төслүүдийн төлөвлөлт, тэдгээрийн бэлтгэл ажил, хэрэгжүүлэлт болон үнэлэлт дүгнэлтийг хийх замаар Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн асуудлуудыг шийдвэрлэх байгууллагын бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;
- Мастер төлөвлөгөөнд санал болгох техникийн оновчтой тогтолцоо бодитоор хэрэгжих эсэхийг судалж үнэлгээ өгөх (өөрөөр хэлбэл, хог хаях журам нэвтрүүлэх, ангилан цуглуулах тогтолцоог баталгаажуулах г.м.).
- Техник, эдийн засгийн үндэслэл тооцоог хийх зорилгоор суурь мэдээллийг цуглуулах (өөрөөр хэлбэл, судалгааны бүсийн онцлог, түүний нөхцөл байдалд тохируулсан эрүүл ахуйн шаардлага хангах ландфилын зураг төслийг гаргах, RDF түлшийг нүүрстэй хольж шатаах аргачлалыг судлах г.м.).
- Хатуу хог хаягдлын менежментийн асуудлаар иргэд, олон нийтийн мэдлэг ухамсарыг дээшлүүлж тэдгээрийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.
- Иргэд, оршин суугчид болон хатуу хог хаягдлын менежментийн холбогдох удирдлагуудад хэрхэн сайжруулах боломжтой арга хэмжээний талаар үзүүлэх.

9.1.2 Туршилтын төслүүдийн сонголт

Монголын талын хамтрагч байгууллагатай ярилцсаны дүнд дараах туршилтын төслүүдийг сонгож Удирдар зөвлөлөөр батлуулав. Туршилтын төслүүдийг судалгааны 2 ба 3 дугаар үе шатны хүрээнд дараах байдлаар хэрэгжүүлэв:

Судалгааны 2 дугаар үе шат:

- T/T 1. Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг яаралтай сайжруулах
- T/T 2. “RDF” хатуу түлш хийж дулааны эрчим хүч үйлдвэрлэх замаар хог хаягдлыг дахин ашиглах
- T/T 3. Рисайкл туршилтын төсөл: Хог хаягдлыг ариун цэврийн цаасаар сольж цуглуулах хөдөлгөөнт “Чиригами кокан” тогтолцоо
- T/T 4. Хүнд жинтэй хог хаягдлыг ачих төхөөрөмжийг судлах
- T/T 5. Хог хаягдлын асуудлаар иргэд, олон нийтийн мэдлэг ухамсарыг дээшлүүлэх

Судалгааны 3 дугаар үе шат:

- Т/Т 1. Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг яаралтай сайжруулах төслийн үргэлжлэл
- Т/Т 2. “RDF” хатуу түлш хийж дулааны эрчим хүч үйлдвэрлэх замаар хог хаягдлыг дахин ашиглах төслийн үргэлжлэл
- Т/Т 6. Хог хаягдал цуглуулах тогтолцоог сайжруулах (хог хаях журам нэвтрүүлэх, ангилан цуглуулах тогтолцоог нэвтрүүлэх)
- Т/Т 7. Хог түүгч нарыг зохион байгуулалтанд оруулах

9.2 Т/Т 1: Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг яаралтай сайжруулах

9.2.1 Төслийн тухай танилцуулга

а. Үндэслэл

Судалгаанд хамрагдсан дүүргүүдийн нутаг дэвсгэрт дөрвөн албан ёсны хогийн төвлөрсөн цэгүүд үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээр нь ил задгай хог хаях хэлбэрээр ажилладаг тул хүрээлэн буй орчинд ноцтойгоор сөрөг нөлөөлж байна. Агаарын бохирдол бий болгож буй галын утаа, хийсч байгаа хог хаягдал зэрэг нь зөвхөн ойрын хүрээлэн буй орчин бус хотын томоохон нутаг дэвсгэрийг хамран, ялангуяа хаврын улиралд сөргөөр нөлөөлж байна.

Дээрх дөрвөн хогийн цэгүүдийн хамгийн том болох Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэг нь судалгаанд хамрагдсан дүүргүүдийн ихэнх хог хаягдал (90% гаруй)-ыг хүлээн авч байгаа бөгөөд хогийг ямар ч хяналтгүйгээр замбараагүй хаяж байна. Тухайн хогийн цэгийн сөрөг нөлөө ноцтой болж байгаа бөгөөд гал гарах тохиолдолд ойр орчимын гэр, байшин руу гал тархаж дамждаг байна. Хогийн цэгийн нөхцлийг сайжруулахгүй бол БОЯ-ны зүгээс хогийн цэгийг хаах арга хэмжээ авна гэж мэдэгдээд байгаа билээ.

Мастер төлөвлөгөөний гол зорилтуудын нэг бол хог хаягдлыг багасгах, дахин ашиглаж, боловсруулалт хийсний дараа хаяж эрүүл ахуйн шаардлага хангасан ландфильн үйл ажиллагаа явуулахад оршино. Гэвч эдгээр ажлуудыг судалгаанд хамрагдсан дүүргүүдийн нутаг дэвсгэр болон нийт улс даяар гүйцэтгэж байсан туршлага байхгүй тул Улаанбаатар хотын захиргаа судалгааны багт хандан өнөөдөр тулгамдаж буй байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэх, эрүүл ахуйн шаардлага хангасан хог хаягдлыг хөрсөөр дарж булах (ландфил) үйл ажиллагаа явуулахын тулд Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг яаралтай сайжруулах туршилтын төсөл хэрэгжүүлэх хүсэлт тавьсан. Энэхүү туршилтын төслийн хамтрагч байгууллага болох Нөөц компани болон ЗАА-ны Хот тохижилтын хэлтэс эрүүл ахуйн шаардлага хангасан ландфильн үйл ажиллагааны санаачлагыг гартаа авах бөгөөд судалгааны баг шаардлагатай үед техникийн туслалцааг үзүүлж байх болно. Төслийн хэрэгжилтийн эхний шатанд хөрөнгө оруулалтын чанартай санхүүгийн туслалцааг ЖАЙКА үзүүлэх болно.


б. Зорилго

Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэг (УЧХЦ)-ийн нөхцлийг яаралтай сайжруулах туршилтын төслийн зорилго нь:

- Зорилго 1. Хууль бус хог хаягдал үүсэх байдлаас сэргийлэх зорилгоор ачиж цуглуулсан хог хаягдлын хяналт, менежментийн тогтолцоо бий болгох, өөрөөр хэлбэл, төвийн 6 дүүрэгт цуглуулсан хог хаягдлыг зөвхөн албан ёсны УЧХЦ дээр буулгах;
- Зорилго 2. Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфил хийх эхний алхам болох УЧХЦ дээр хог хаягдлыг буулгахдаа цэгийн дотор тодорхой газар буулгах;
- Зорилго 3. УЧХЦ дээрх хуучин хогийн цэгийн ландфилийг нөхөн сэргээж цаашид аль болох эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино.

с. Сайжруулах төлөвлөгөө ба Т/Т 1-ийн хэрэгжүүлэлт

Сайжруулах төлөвлөгөө ба Т/Т 1-ийн хэрэгжилтийг дараах зураг болон хүснэгтэд үзүүлэв. Т/Т 1-ийн хэрэгжүүлэхэд ЖАЙКА-ийн судалгааны баг цэгийн нөхцлийг хэрхэн сайжруулах төлөвлөгөө болон барилга байгуламж барих асуудлыг хариуцсан бол Улаанбаатар хотын захиргаа/Нөөц компани нь хуучин хур хог хаягдлыг хөрсөөр дарж газрыг эрүүлжүүлэх, эрүүл ахуйн шаардлага хангах ландфилийн үйл ажиллагааг хариуцаж хангав. Хоёр тал хамтран ажилласан болно.



Зураг 9-1: УЧХЦ-ийн нөхцлийг яаралтай сайжруулах төлөвлөгөө

Хүснэгт 9-1: Сайжруулах төлөвлөгөө, хариуцах байгууллага ба Т/Т 1-ийн гүйцэтгэл

Зорилго	Сайжруулах төлөвлөгөө	Хариуцах байгууллага	Гүйцэтгэл
Зорилго 1	• Хог хаягдлыг ачиж цуглуулах үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг бүртгэж тэдгээрийг хянах тогтолцоо байгуулах	ЗАА/Нөөц	Автопүү 2005 оны 12 дугаар сарын 26-нд ашиглалтанд орсон бөгөөд ТҮК болон бусад байгууллагуудын хогны машинуудыг бүртгэж холбогдох мэдээллийг хянах байрны компьютер дээр тоон хэлбэрээр оруулж эхэлсэн.
	• Төсвийг нь нэмэгдүүлэх асуудлыг оролцуулан Нөөц компанийн хяналт, менежментийн чадавхийг бэхжүүлэх	ЗАА	Нөөц компанийн хяналт, менежмент хийх чадавхийг туршилтын төсөл, Японы сургалт зэрэг арга хэмжээний хүрээнд сайжруулж 2006 оны 1 дүгээр сараас Нөөц компанийн төсвийг 4 удаа нэмэгдүүлснээр 2006 оны төсөв нь 150,000,000 төгрөг болов.
	• Шинэ хянах байр барих	ЖАЙКА СБ	Шинэ хаянах байрыг автопүүний хамт барьж ашиглалтанд оруулаад үйл ажиллагааг 2005 оны 12 дугаар сарын 26-наас сэхлүүлсэн.
	• Хогийн цэг рүү нэвтрэх бүх замуудыг нэгтгэж урд замаар оруулдаг болгох	ЗАА/Нөөц	Хүрээлэх далан болон хашаа барьж хогийн цэг рүү урд талаас орохоос өөр замаар нэвтрэх боломжгүй болно.
	• Автопүү суурилуулах	ЖАЙКА СБ	2005 оны 12 дугаар сарын 26-нд автопүү суурилуулах ажил дууссан
	• Хог хаягдлыг цуглуулах, хогийн цэг дээр буух хог хаягдлыг хянах, менежмент хийх мэдээллийн сан байгуулах	ЖАЙКА СБ	Нөөц компанийн ажилтан нарт ЖАЙКА СБ-аас ажлын буюу хянах байранд ойролцоогоор нэг жилийн хугацаатай сургалт явуулсан. Одоогийн байдлаар гурван диспетчер автопүү ажиллуулах хангалаттай чадвартай болсон. Хог хаягдлыг цуглуулах, хогийн цэг дээр буух хог хаягдлыг хянах, менежмент хийх мэдээллийн сан байгуулан автопүүний мэдээллийг ашиглан сарын тайланг ЗАА-нд гаргаж өгч байна.
	• Хуль бус хог хаягдлыг мониторинг хийх, хяналт тавих тогтолцоог байгуулах	ЗАА/Нөөц	Хууль бус хог хаягдлыг хэрхэн хянах талаар ЗАА судалж байна. ЖАЙКА СБ барилгын хог хаягдлын судалгааг гүйцэтгэж холбогдох дүгнэлтийг гаргаад байна.
	• Хогийн цэг дээр хог хаягдал буулгахад хураадаг төлбөрийг дахин судлах	Монголын тал ба ЖАЙКА СБ	Тэрхүү төлбөрийн асуудлыг хог хаягдал гаргасны төлбөрийн тогтолцоо болон тарифчлалын судалгааны хүрээнд хамтатгаж судлав. Шинэ тарифын тогтолцоог 2006 оны 9 дүгээр сарын 1-нээс мөрдөж эхлэв.
• Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах асуудлыг бэхжүүлэх	Монголын тал ба ЖАЙКА СБ	Хууль бус хог хаягдлыг хянах тогтолцоог судалж дүгнэж холбогдох саналыг эцсийн тайланд оруулав.	
Зорилго 2	2.1. Хашаа, хаалга ба хүрээлэх далан байгуулж хогийн цэгийн хилийн зурвасыг тогтоох	ЖАЙКА СБ	УЧХЦ-ийн эргэн тойронд хүрээлэх далан болон хашаа, хаалга байгуулж хилийн зурвасыг тогтоов.
	2.2. УЧХЦ рүү гэр хороолол түрэн орж ирэх байдлаас сэргийлэх зорилгоор хашаа эсвэл тусгаарлах бүс байгуулах	ЗАА	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Байгаль орчны байнгын хорооны шийдвэрээр УЧХЦ-ийн тусгаарлах бүсийг баталж тусгай тэмдэг, хилийн тэмдэглэлийн байгууламжуудыг барьсан. Бүсийн холбогдох журам, тогтоолыг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдаж зохицуулагдах болно. Тусгаарлах зурвасын хилийг тогтоох зорилгоор ногоон байгууламж байгуулсан бөгөөд таримал мод нь тодорхой арчилгаа тордолгоотой ургах боломжтойг харуулав.
	2.3. Хог хаягдлыг буулгах цэг байгуулах зорилгоор хамгаалах болон хүрээлэх далан байгуулах (ажлын талбай)	ЖАЙКА СБ	Хог хаягдлыг буулгах цэг байгуулах зорилгоор хамгаалах болон хүрээлэх далан байгуулах (ажлын талбай) ажлыг гүйцэтгэсэн. 1 дүгээр ажлын талбай хогоо дүүрч 2005 оны 12 дугаар сард 2 дугаар хамгаалах даланг барив. 2006 оны 9 дүгээр сард 3 дугаар хамгаалалтын далан баригдав.
	2.4. Хогийн цэг доторх замыг сайжруулах	ЖАЙКА СБ ба Нөөц	Хогийн цэг доторх төв замыг байгуулсан боловч бульдозер эвдэрч хогны машинууд ажлын талбай руу нэвтрүүлэх боломжгүй болсоноор замын зарим хэсэг хог хаягдлаар дүүрч бөглөрсөн байдалтай байгаа. Замыг хогоор бөглөрөх байдлаас сэргийлэх зорилгоор баруун тийш нь дахин байгуулж тавив.

	2.5. Хогийн цэг рүү нэвтрэх зам дагуу болон ойр орчимд тархсан хог хаягдлыг цэвэрлэх	ЗАА ба ЖАЙКА СБ	ЗАА-ны гүйцэтгэгч болон ЖАЙКА-ийн гүйцэтгэгч нар хогийн цэг рүү нэвтрэх зам дагуу болон ойр орчимд тархсан хог хаягдлыг цэвэрлэв. Цуглуулсан хог хаягдлаар далан барихад ашиглав. Нэвтрэх замын дагуух хог хаягдлыг үе үе цэвэрлэж байна.
Зорилго 3	3.1. Хий зайлуулах байгууламж суурилуулах	ЖАЙКА СБ	УЧХЦ дээр нийт 18 нэгж хий зайлуулах байгууламж суурилуулсан бөгөөд заримыг нь уртасгах шаардлагатай болсон байна.
	3.2. Борооны усны суваг шуудуу барих	ЖАЙКА СБ	Борооны ус зайлуулах сувгийг хүрээлэх далангийн хамт байгуулсан.
	3.3. Бохир шингэн цэвэрлэх байгууламж суурилуулах	ЖАЙКА СБ	Бохир шингэн цуглуулах болон цэвэрлэх байгууламжуудыг байгуулсан. Одоогоор гадагшаа гарсан бохир шингэн ажиглагдахгүй байна.
	3.4. Дулаан гараж барих	ЖАЙКА СБ	Өвлийн улиралд ландфилын үйл ажиллагааг тасралтгүй хангах зорилгоор дулаан гараж барьсан. Усны машин болон бульдозерийг дотор нь тавьж байна.
	3.5. Эмнэлгийн хог хаягдлыг цэг	ЖАЙКА СБ	Эмнэлгийн хог хаягдлыг хотын хатуу хог хаягдлаас тусгаарлах зорилгоор эмнэлгийн хог хаягдлыг цэгийн байгуулсан.
	3.6. Хуучин хогийн цэгийг түрж тэгшлэх, хөрсөөр хучиж нөхөн сэргээх	ЗАА/Нөөц	ЗАА-ны гүйцэтгэгч нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэж нийт 5 га газрыг эрүүлжүүлэв. Тэрхүү ажлыг гүйцэтгэхэд нэг сар зарцуулж, нэг ковш, нэг эксковатор, гурван самосвал машин ашиглав. Өвлийн улиралд хөрс хөлддөг газар шорооны ажлыг зуны улиралд л хийх боломжтой.
	3.7. Хог хаягдлыг хогийн цэг дээр буулгах төлөвлөгөөний төслийг гаргаж түүнийгээ хэрэгжүүлэх	Нөөц ба ЖАЙКА СБ	УЧХЦ-ийн журам ба хогийг хэрхэн хаях төлөвлөгөөний төслийг ЖАЙКА СБ боловсруулав. Нөөц компани 2005 оны 11-р сарын 1-нээс эхлэн хуваарийн ажиллаж байгаа боловч Нарантуул захын хог хаягдал шөнө ирдэг тул тэр болгон тогтоосон хуваарийн дагуу ажиллахгүй байна. Энэхүү асуудлыг зохицуулахын тулд хог хаягдлыг цуглуулдаг ажлыг зохицуулах шаардлагатай.
	3.8. Хог хаягдлыг нятруулж тэгшлэх	Нөөц	2006 оны эцсийн байдлаар хог хаягдлыг түрж нягтруулах хоёр бульдозер байгаа боловч тэдгээр нь хуучин тул байнга эвдэрч найдвартай үйл ажиллагаа явуудж чадахгүй байна.
	3.9. Хөрсөөр хучилт хийх	Нөөц	Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилын үйл ажиллагаа явуулах ихэнх барилга байгууламжуудыг баригдсан тул ЗАА/Нөөц компани өдөр тутмын хөрсөөр хучих ажлыг гүйцэтгэж болох боловч хөрсөөр хучилт хийхэд шаардагдах экскаватор, самосвал зэрэг нь техник хангалтгүй байгаа тул одоогоор бараг хөрс хучилт хийгдэхгүй байна. Түүнчлэн өвлийн хөрс хөлддөг тул хөрс олж авах ямарч боломжгүй байдаг.
	3.10. Хог түүх ажиллагааг хянаж зохицуулах	Нөөц	2005 оны 8 дугаар сард Нөөц компани ЖАЙКА СБ-ийн дэмжлэгтэйгээр шинээр ирсэнээс бусад бүх хог түүгч нарыг бүртгэж УЧХЦ-ийн журмыг боловсруулав. Хог түүгч нарын уулзалтыг 2006 оны 5 дугаар сараас долоо хоног тутам зохион байгуулсан бөгөөд одоогоор 220 хог түүгч нар бүртгэгдэж тэдгээр нь фото зурагтай үнэмлэхтэй болсон билээ.
	3.11. Хогийн цэгийн үйл ажиллагааг хянах хороо байгуулж тогтмол хяналт хийх	ЗАА ба ЖАЙКА СБ	9 гишүүнтэй хяналтын хороо байгуулсан ба тогтмол хяналтын үйл ажиллагааг 2005 оны 7 ба 10, 2006 оны 5 ба 9 дүгээр саруудад нийт дөрвөн удаа гүйцэтгэсэн. Хорооны даргыг өөрчлөн Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын ажилтангаар томилов.

9.2.2 Сургамж ба зөвлөмж

а. Дүгнэлт

Хотын захиргаа, Нөөц компани, УЧХЦ-ийн дэргэд амьдардаг оршин суугчид, УЧХЦ дэр ажилладаг хог түүгчид зэрэг төслийн холбогдох байгууллага, иргэд туршилтын төслийн үйл ажиллагааг ихээхэн дэмжиж байна. Ялануяа, эвгүй үнэр, замбараагүй тархах хог хаягдал, хортон шавьж зэрэг байгаль орчин бохирдуулах сөрөг асуудлуудыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэв.

Олон барилга байгууламж байгуулсан нь нөхцөл байдлыг гадна талаас харсан ч сайжруулсан боловч цаашид үйл ажиллагаа, үйлчилгээний ажлууд сайжрах эсэх нь ихээхэн чухал юм. Жишээбэл 2005 оны 12 дугаар сард бульдозер эвдэрч зогсох болон зааварчилгаа өгөгдөөгүй байсан учир хогны машинууд хог хаях талбай дээр хүрч чадалгүй хогоо хогийн цэг доторх зам дээр буулгасан байв. Улмаар зам битүүрч хогийн цэг рүү орох боломжгүй болсноор хогны машинууд хогийн цэгийн гадуур хогоо буулгаж байв. Тэрхүү байдлыг дараах фото зургаар үзүүлэв.



Зам дээр буулгаж хаясан хог



Хашаанаас гадуур хаясан хог

Өвлийн улиралд хогийн цэг дээр гал ба эвгүй үнэр гарах, хог хаягдал замбараагүй тархах явдлууд бага байдаг бөгөөд салхины эрч бусад улирлыг бодвол харьцангуй сул байдаг байна. Иймд хаврын улирал ирж байгаатай холбогдуулан шаардагдах бэлтгэл ажил хийх нь чухал байна.

б. Зөвлөмж

Сайжруулсан барилга байгууламж ашиглан ландфилын үйл ажиллагааг хэдэн сар хэрэгжүүлээд дараах дүгнэлтэд хүрэв:


б.1 Хуучин бульдозер солих

Ландфилын найдвартай үйл ажиллагааг хангах хамгийн чухал төхөөрөмж бол бульдозер юм. 2005 оны эцсийн байдлаар хогийн цэг дээр 15 жилээс дээш хугацаанд ашиглаж байгаа хоёр ОХУ-д үйлдвэрлэсэн бульдозер ажиллаж байв. Гэхдээ нэг бульдозер нь бүрэн зогсож одоогоор түүнийг сэлбэг болгон ашиглаж байна. Нөгөө бульдозер нь байнга эвдэрдэг бөгөөд нэг эвдрэхдээ хэдэн долоо хоногоор сул зогсолт хийж байна. Өөрөөр хэлбэл техникийн хувьд дэндүү хуучирсан явдал цаашид ашиглаж засварлах тусам үргүй зардал гарч, цаг хугацааны алдагдалтай болох бөгөөд яаралтай, сайн бульдозер авч солих шаардлагатай байна.

2006 оны эцсийн байдлаар ЖАЙКА-ийн судалгаан багийн зөвлөмжийн дагуу УБ хотын захиргаа Хятадын хуучин бульдозер худалдан авч одоогоор УЧХЦ дээр хоёр бульдозер байна.

б.2 Хяналт, зохицуулалттай ландфилын үйл ажиллагааг ханагахад хог түүгч нартай нэгдсэн ойлголтонд хүрэх ба Мастер төлөвлөгөөний хүрээнд гаргах санал

Туршилтын төслийн хүрээнд санал болгож буй ландфилын үйл ажиллагаа болон шинээр байгуулах эрүүл ахуйн шаардлага хангасан ландфил дээр хог түүх үйл ажиллагааг бүрэн хориглох юм. Иймд хяналт зохицуулалттай болон эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилын найдвартай үйл ажиллагааг хангахад 3 дугаар үе шатны туршилтын төсөл хэрэгжүүлж хог түүгч нартай нэгдсэн нэг ойлголтонд хүрэхийн тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай.



Зураг 9-2: УЧХЦ дээр 3 дугаар үе шатны хүрээнд хэрэгжүүлэх нэмэлт туршилтын төсөл

б.2.1. Хяналт, зохицуулалттай ландфилын үйл ажиллагааг ханагахад хог түүгч нартай нэгдсэн ойлголтонд хүрэх

Хяналт, зохицуулалттай ландфилын үйл ажиллагааг ханагахад хогны машинууд зөвхөн зааж өгсөн, тодорхой газар хогоо буулгаж болно. Туршилтын төслийн хүрээнд тэрхүү арга хэмжээг авснаар хог түүх ажлын талбайн хэмжээг багасгаж хог түүх үйл ажиллагааг хүндрүүлэх юм. Иймд зарим хог түүгч нар туршилтын төслийн явцтай санал нийлэхгүй, сэтгэл дундуур байгаа нь ойлгомжтой юм.

Туршилтын төслийн үндсэн зорилго бол хяналт, зохицуулалттай ландфилын үйл ажиллагааг нэвтрүүлэх зорилготой тул энэ асуудлаар нэгдсэн ойлголтод хүрэх боломжгүй ч гэсэн тэдгээр хүмүүсийн дэмжлэгийг авахын тулд шударга худалдааг хангах, хогийн цэгийг эрүүл нөхцөлтэй болгох зэрэг арга хэмжээ авч болно.

Дээр дурьдсан хог түүгч нарын саналын дагуу хог түүгч нар ажлын нөхцөл байдлыг сайжруулах хүсэлт гаргаж байсан. Бүх санал хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй ч гэсэн зарим нэг, жишээлбэл, тэдгээрийн цуглуулсан хаягдал түүхий эд борлуулах шудрага худалдааны газар байгуулах зэргийг шийдвэрлэж болох юм. Түүнчлэн өвлийн улиралд хог түүгч нарыг оромжоор хангаж ландфилын цэг дээр гал гаргахгүй байх асуудлыг зохицуулж болох юм.

b.2.2. УЧХЦ дээр ялгах цехийн үйл ажиллагаа

Мастер төлөвлөгөөний хүрээнд санал болгох эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилын үйл ажиллагааг хангахын тулд хог түүгч нарын үйл ажиллагааг хориглох асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Иймд Мастер төлөвлөгөөний хүрээнд хог түүгч нарыг ландфил дээр бус ялгах цех дээр ажиллах боломжийг нь олгож ангилан цуглуулах тогтолцоог нэвтрүүлж хаягдал түүхи йэд цуглуулах үр өгөөжийг дээшлүүлнэ. Иймд ландфил дээр ажиллахгүй, түүний оронд ялгах цех дээр ажиллах талаар нэгдсэн ойлголтонд хүрэх боломжтой эсэх асуудлыг судлахын тулд одоогийн УЧХЦ туршилтын ялгах цех байгуулж ангилан цуглуулсан хог хаягдлыг ялгах үйл ажиллагаа нэвтрүүлэн дүн шинжилгээ хийж болох юм.

Туршилтын төслийн хүрээнд ангилан цуглуулах тогтолцоог туршиж улмаар ялгах цех дээр үнэ цэнэтэй хаягдал бууж хог түүгч нарт илүү боломж олгогдох юм. Хог түүгч нарыг ялгах цех дээр ажиллуулах туршилтын төслийг хэрэгжүүлж цаашид Мастер төлөвлөгөөний хүрээнд санал болгох эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилын үйл ажиллагааг нэвтрүүлэх үйлсэд нэлээд хувь нэмэр болох юм.

b.2.3. УЧХЦ дээр RDF түлш үйлдвэрлэх

Мастер төлөвлөгөөний хүрээнд ялгах цехээс гарах муу чанарын цааас, хуванцар үлдэгдэл хаягдлыг RDF үйлдвэрт шилжүүлэнэ гэж төлөвлөх бөгөөд RDF түлшийг үйлдвэрлээд нүүрсний альтернатив түлш хэлбэрээр ДЦС-д нийлүүлэх болно.

Судалгааны 2 дугаар үе шатны хүрээнд 12 тонн RDF түлшийг Налайхын дулааны станц дээр шатаах туршилт хийх журмаар үйлдвэрлэв. Судалгааны 3 дугаар үе шатны хүрээнд RDF түлшийг одоогийн дулааны станц дээр ашиглах эдийн засгийн үр ашиг, тооцоог хийх зорилгоор RDF түлшийг илүү их хэмжээгээр үйлдвэрлэж удаан хугацаанд шатаах туршилт хийж дүн шинжилгээ гаргана.

RDF түлш үйлдвэрлэхийн тулд дээр дурьдсан ялгах цехийн үлдэгдэл хаягдлыг ашиглаж түүхий эд худалдан авах зардалаа хэмнэх бөгөөд Мастер төлөвлөгөөнд дурьдсан саналыг хэрэгжүүлэх боломжийг судлах зорилгоор түлшийг УЧХЦ дэргэд үйлдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн боловч төслийн төсвийн хүндрэлээс шалтгаалан 3 дугаар үе шатны хүрээнд RDF түлшийг УЧХЦ-ээс гадна үйлдвэрлэв.

b.3 Хог түүгч нарын зохион байгуулалт

Санал асуулгын дагуу хогийн цэг дээр хог түүгч нарын дунд аливаа зохион байгуулалт байхгүй байна. Мастер төлөвлөгөөний дагуу хог түүгч нар зохион байгуулалтанд орж ялгах цех дээр ажиллах ёстой бөгөөд аливаа зохион байгуулалт байхгүй тохиолдолд тэдгээр хүмүүсийг хянахад хүндрэлтэй болно.

Одоогийн УЧХЦ-ийн бас нэг асуудал хүүхэд хог түүгч нар. Тэдгээр хүүхдүүд сахилаггүй, дүрэм журам мөрддөггүй. Автопүүн дээр зогсож байгаа хогны машин дээр авирч машины жинд нөлөөлж байна. Түүнчлэн, хогны машин дээр гарах нь аюултай бөгөөд энэхүү асуудлаар насанд хүрсэн хог түүгч нар ч санаа зовниж байна.

Дээрх асуудлыг шийдвэрлэхэд зөвхөн дүрэм журам сахиулах, шийтгэх арга хэмжээ авах нь хангалтгүй бөгөөд нэмэлт тусламж дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Канадын зөвлөх компани Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр “Хог түүгч төсөл” хэрэгжүүлэх ёстой байсан боловч тэрхүү төсөл хэрэгжээгүй тул ЖАЙКА-ийн судалгаа баг судалгааны 3 дугаар үе шатны хүрээнд хог түүгч нарыг зохион байгуулах ажлыг гүйцэтгэв.

с. Сургамж

Туршилтын төсөл хэрэгжүүлснээр дараах сургамжтай болсон.

- Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфил хийх анхны алхам бол тодорхой хилийн зурвас тогтоох
- Хатуу хог хаягдлын менежментийг найдвартай хэрэгжүүлэх зорилгоор хогийн төвлөрсөн цэг дээр ирж буй хогны машины жинг хэмжих.
- Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилын үйл ажиллагааг хангахад техникийн бүрэн ажиллагаатай бульдозертай болох
- Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфил хийхийн тулд экскаватор, самосвал зэрэг бусад машин төхөөрөмж шаардлагатай бөгөөд тэдээгрийн үйл ажиллагаа, үйлчилгээг хангах талаар техникийн тусламж авах нь чухал.
- Хог түүгч нарын асуудлыг шийдвэрлэхэд урт удаан хугацааны дэмжлэг шаардлагатай.

9.2.3 Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэг (УЧХЦ)-ийг хаах тухай

а. Төлөвлөлт

УЧХЦ-ийн ашиглалтын хүчин чадал дуусч хэдэн жилийн дараа ландфилын үйл ажиллагаагаа хаах болно. Хогийн төвлөрсөн цэгийг холбогдох дүрэм журмын дагуу хаахын тулд Хотын захиргааны зүгээс хогийн цэгийг хаах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагатай.

УЧХЦ-ийг хаах төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 9-2: УЧХЦ-ийг хаах төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүд, 2005 оны байдлаар

Зүйл	Нэгж	Тоо
Хогийн цэгийн талбай	га	17.0
Хуучин хур хогийн цэг (баруун хэсэг): A1	га	8.0
Одоогийн ажлын талбар (зүүн хэсэг) : A2	га	9.0
Ландфилын үйл ажиллагааны хугацаа	Жил	3 жил
Ландфилын урьдчилсан хүчин чадал		
• 2005	м ³	85,000
• 2006	м ³	108,000
• 2007	м ³	120,000
• 2008	м ³	132,000

б. Хаах төлөвлөгөө

б.1 Бүрэн гүйцэд хаах хүртэл хийх ландфилын үйл ажиллагаа

б.1.1. Үндсэн зарчим

УЧХЦ-ийн талбай нь хэсэг буюу баруун хэсэгт нь байрлах хуучин хур хогийн цэг (А1 гэж нэрлэх) болон зүүн хэсэгт нь байрлах одоогийн ашиглаж буй ажлын талбар (А2 гэж нэрлэх) гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. А1 хэсгийг хөрсөөр хучиж нөхөн сэргээх үйл ажиллагаа явагдсан тул А2 хэсэгт ландфилын үйл ажиллагаа явуулна.

б.1.2. Жилдээ булах хэмжээ

2005 оноос цаашид жил бүр булах хог хаягдлын хэмжээг Нөөц компанийн бүртгэл мэдээлэл болон Судалгааны багийн урьдчилсан дүн дээр үндэслэн автопүү суурилуулахаас өмнө хийсэн тооцоог дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 9-3: Булах хэмжээ

	Өдөрт булах хэмжээ	Жилийн булах хэмжээ		Нягтруулалт хийсний дараах ландфилын хэмжээ	Нийт хуримтлуулсан хэмжээ
	тонн/өдөр	тонн/жил	м3/жил	м3/жил	м3
2005	232.9	85,009	106,261	85,009	85,009
2006	295.4	107,821	134,776	107,821	192,830
2007	329.2	120,158	150,198	120,158	312,988
2008	362.5	132,313	165,391	132,313	445,300

б.1.3. Ландфилын хүчин чадал

Хогийн цэгийн А2 дугаар хэсгийн ландфил хийх хүчин чадлын тооцоог дараах байдлаар хийв.


Хүснэгт 9-4: Хогийн цэгийн зүүн хэсэг дэх ландфилын хүчин чадал

	Хог булах талбай	Дундаж талбай	Хогны үений өндөр	Хогны эзлэхүүн	Далан талбай	Далан урт	Далан эзлэхүүн	Нийт эзлэхүүн	Хуримт эзлэхүүн
	м2	м2	м	м3	м2	м	м3	м3	м3
Анхны үе	0.0								
1-р үе	7,540.0	3,770.0	4.4	16,588.0	25.0	125.0	3,125.0	19,713.0	19,713.0
2-р үе	10,210.0	8,875.0	2.5	22,187.5	25.0	165.0	4,125.0	26,312.5	46,025.5
3-р үе	11,770.0	10,990.0	2.5	27,475.0	25.0	210.0	5,250.0	32,725.0	78,750.5
4-р үе	13,200.0	12,485.0	2.5	31,212.5	25.0	260.0	6,500.0	37,712.5	116,463.0
5-р үе	16,400.0	14,800.0	2.5	37,000.0	25.0	300.0	7,500.0	44,500.0	160,963.0
6-р үе	19,230.0	17,815.0	2.5	44,537.5	25.0	340.0	8,500.0	53,037.5	214,000.5
7-р үе	24,600.0	21,915.0	2.5	54,787.5	25.0	370.0	9,250.0	64,037.5	278,038.0
8-р үе	36,080.0	30,340.0	2.5	75,850.0	25.0	410.0	10,250.0	86,100.0	364,138.0
9-р үе	52,240.0	44,160.0	2.5	110,400.0	25.0	450.0	11,250.0	121,650.0	485,788.0

Дээрх тооцоон дээр үндэслэн УЧХЦ-ийг гурван жил буюу 2008 он хүртэл ашиглаж түүнээс хойш холбогдох хаах арга хэмжээ авах шаардлагатай.

б.1.4. УЧХЦ-ийг эцсийн байдлаар хаах зураг төлөвлөлт

Хог болон хөрсөөр дүүргэлт хийсний үндсэн дээр хогийн төвлөрсөн цэгийн дүр зураг дараах байдалтай болно.



Зураг 9-3: УЧХЦ-ийг хаах байдлын зураг

b.2 Хаах төлөвлөгөө

b.2.1. Хөрсөөр хучих төлөвлөгөө

Өвлийн улиралд ашиглах хөрсийг зун ухаж овоолон бэлтгэх болно.

Хотын захиргааны зүгээс УЧХЦ-ийн ойролцоо хөрс авах боломжтой. Хөрс хучилт хийх зузаан дараах нөхцлийг хангана.

- Тэгш газар: 50 см
- Налуу газар: 50 см

УЧХЦ-ийг хаахад тайлбайг бүрэн хучих ба шаардагдах хөрсний хэмжээг дараах байдлаар тооцов.


$$9 \text{ га} \times 0.50 \text{ м зузаан} = 45,000 \text{ м}^3$$

Ландфилын үйл ажиллагааны үед хүрээлэх даланг хөрсөөр хучих ажил хийгдэх тул хаах үед шаардагдах хөрсний хэмжээ дээр дурьдсан хэмжээнээс бага байх болно.

Аль болох бага хэмжээний хөрс ашиглахын тулд хөрсөөр хучилт хийхийн өмнө бульдозер ашиглаж урьдчилан түрж тэгшлэх, налуулах шаардлагатай.

b.2.2. Усны бохирдолтын хяналт

Хогноос гарах бохир шингэнг ландфилын үйл ажиллагаа эхлэхээс өмнө хогийн цэгийн хамгийн доод цэгт ухаж байрлуулсан бохир шингэн цуглуулах байгууламж ашиглан цуглуулах болно. Цугларах бохир шингэн хамгаалах далангийн урд байгуулсан бохир шингэн цэвэрлэх байгууламжид хадгалагдах бөгөөд тэдгээр байгууламжуудын зураг төлөвлөлтийг дараах зураг дээр үзүүлэв.




Зураг 9-4: Бохир шингэн цуглуулах системийн зураг

б.2.3. Ялгарах хийг менежмент хийх төлөвлөгөө

Хий зайлуулах босоо хоолойнуудыг суулгаж хийг хянах болно.

Ландфилын үйл ажиллагааны явцын дагуу босоо байрлалтай хий зайлуулах хоолой суулгах нь зүйтэй. Хотын захиргаа төлөвлөсөн тусгай цэг дээр ландфилын үйл ажиллагаа эхлэхээс өмнө босоо хоолой суулгах шаардлагатай.

Хогийн цэгийн А2 хэсэгт суурилуулсан хий зайлуулах байгууламжуудын байршлыг дараах зураг дээр үзүүлэв.



Зураг 9-5: УЧХЦ дээр хий зайлуулах хоолой суурилуулсан зураг

б.2.4. Ирээдүйн газар ашиглалтын төлөвлөгөө

Холбогдох байгууллагууд цаашид тухайн газрыг хэрхэн ашиглах талаар хэлэлцэж тохирох болно. Хаагдах УЧХЦ нь шинээр байгуулагдах НЭХЦ-ийн дэргэд байрлалтай тул шинэ хогийн төвлөрсөн цэгийн тусгаарлах зурвас болгон ашиглах нь зүйтэй үзэж байна. Цаашид гэр хорооллын бүс УЧХЦ-ийн бүс рүү нэвтрэн орох байдлаас сэргийлэх зорилгоор мод тарих, хашаа барих зэрэг шаардагдах арга хэмжээ авах болно.

б.2.5. Мониторинг хийх төлөвлөгөө

Ландфилын бүс тогтвортой байдалтай болох хүртэл холбогдох мониторингийн арга хэмжээ УЧХЦ дээр авах болно. (ихэвчлэн хогийн цэг хаагдсанаас хойш 15 жил). Мониторинг хийх зүйлүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв..

Хүснэгт 9-5: УЧХЦ-ийн мониторингийн төлөвлөгөө

Зүйл	Байгууламж	Давтамж	Авах арга хэмжээ
Гадна байдал	Ландфилын талбай	Сард нэг удаа	<ul style="list-style-type: none"> Хөрсөөр хучих Хөрсөөр хучсан хог (суулт, бусад өөрчлөлт.) Суваг шуудууны засвар үйлчилгээ Бусад
Гүний ус	Орчимын худаг	Жилд хоёр удаа	Цахилгаан дамжуулах чанар, CL^- рН
Бохир шингэн	Бохир шингэн цэвэрлэх сан	Бохир шингэн гарах тохиолдолд	Цахилгаан дамжуулах чанар, CL^- рН
Ландфил хий	Хий зайлуулах хоолой	Жилд дөрвөн удаа	CH_4 , CO_2 , H_2O , хэм
Суулт	Суулт хянах төхөөрөмж	Жилд дөрвөн удаа	Суултын түвшин

9.3 Т/Т 2: Дулаан эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор хог хаягдлыг "RDF" хатуу түлш болгон ашиглах

9.3.1 Оршил

а. Үндэслэл

Улаанбаатар хотын хатуу хог хаягдал их хэмжээний хуванцар, цаасан төрлийн хог хаягдал агуулж байна. Ялангуяа, орон сууцны хорооллын хуванцар ба цаасан төрлийн хог хаягдал 36% бөгөөд 34% эзлэх хүнсний хог хаягдлын хэмжээнээс их байна. Хуванцар сав, картон зэрэг бага хэмжээний хог хаягдлыг одоогоор дахин ашиглаж байгаа бөгөөд бусад хог хаягдлыг шууд хогийн төвлөсрөн цэг дээр дарж булж байна. Тэдгээр төрлийн хог хаягдал нь ялзралт, нягтруулалтад ороход бэрхшээлтэй байдаг тул хог хаягдал замбараагүй тархах, тогтворгүй байдлыг үүсгэж ландфилын үйл ажиллагаанд хүндрэл учруулдаг. Улаанбаатар хотыг хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хороолол болон орон сууцны хороололд амьдрах хүн амын харьцаа 2006 оны 46:54% гэсэн байдлаас 2020 онд 18:82% болж өөрчлөгдөнө гэж тооцжээ. Тэрхүү байдал хуванцар болон цаасан төрлийн хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлж улмаар цаашид тэдгээр төрлийн хог хаягдал илүү ноцтой асуудал үүсгэх болно.



УЧХЦ дээр замбараагүй тархах хуванцар ба цаасан төрлийн хог хаягдал



Зөөврийн хашаанд хийсч наалдсан хуванцар ба цаасан төрлийн хог хаягдал

Дээрх асуудлуудыг шийдвэрлэхийн тулд одоогоор огт дахин ашиглагдахгүй байгаа цаас, хуванцар гэх мэт хог хаягдлыг цуглуулж RDF (RDF: хаягдлаар хийсэн түлш) түлш үйлдвэрлэнэ. Үйлдвэрлэсэн RDF түлшийг одоогоор ашиглаж байгаа өндөр температурт байнгын шаталттай байгууламжинд (цахилгаан болон дулаан үйлдвэрлэх

станц) шатааж холбогдох мэдээллийг цуглуулах болно. Түүний дүнд хэцүү гэгдэх төрлийн хог хаягдлыг эрчим хүч болгон эргүүлэн дахин ашиглаж улмаар нүүрс зэрэг эрчим хүчний хэмнэлтэд хувь нэмэр болно.

в. Зорилго

Т/Т 2-ийн зорилго:

- Одоогоор хаягдал түүхий эд болгон дахин ашиглахгүй байгаа цаас, хуванцарыг ашиглаж RDF үйлдвэрлэх;
- Байнгын өндөр температурт шаталт явагддаг байгууламжид (цахилгаан болон дулаан үйлдвэрлэх станц) үйлдвэрлэсэн RDF түлшийг нүүрстэй хольж шатааж ялгарах хийний чанар, нүүрсний хэрэглээний хэмнэлт, горимын асуудлууд зэрэг байдалд хэрхэн нөлөөлөх талаар судалгаа шинжилгээ хийх;
- Улаанбаатар хотын иргэдэд RDF түлшийг үйлдвэрлэх болон шатаах технологийг үзүүлж RDF-ийн тухай ойлголттой болгоход оршино.

9.3.2 RDF үйлдвэрлэх

а. Үйлдвэрлэх

RDF түлшийг үйлдвэрлэхэд түүхий эдийг нь нягтруулан халааж үйлдвэрлэдэг. Японд RDF түлшийг үйлдвэрлэхэд ихэвчлэн нягтруулах аргачлал буюу даралтаар үүсэх дулааны эрчим хүчээр хуванцар хайлуулж түлш хийдэг боловч нягтруулах төрлийн RDF-ийн төхөөрөмжийг Японоос тээвэрлэн авчиргахад цаг хугацааны болон зардал хөрөнгийн асуудлыг шийвэрлэхэд бэрхшээлтэй болно. Иймд бид туршилтын төслийн үер RDF түлшийг үйлдвэрлэхдээ хуванцарыг гадна талаас нь халааж хайлуулан хийсэн. RDF түлшийг нүүрстэй хольж шатаах туршилтыг хоёр удаа буюу 2006 оны 2 дугаар сар болон 10 дугаар сард тус тус гүйцэтгэсэн. Туршилтыг гүйцэтгэхээс өмнө 12 тонн RDF түлшийг 2005 оны 12 дугаар сараас 2006 оны 1 дүгээр сарын хооронд, 24 тонн RDF түлшийг 2006 оны 8 дугаар сараас 9 дүгээр сарын хооронд тус тус үйлдвэрлэсэн.

RDF түлшийг үйлдвэрлүүлэхээр Улаанбаатар хотод байрлалтай Төв Морьт Хангай ХХК-тай гэрээ байгуулсан.

б. Үр дүн

Шатаах туршилтын үер ашигласан RDF болон нүүрсний чанарыг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 9-6: RDF болон нүүрсний чанар

Физик бүтэц		RDF		Нүүрс	
		1-р туршилт	2-р туршилт	1-р туршилт	2-р туршилт
Өндөр илчлэгтэй (HCV)	(ккал/кг)	5,820	3,320 ^{*1}	3,875	4,700 ^{*1}
Бага илчлэгтэй (LCV)	(ккал/кг)	5,290 ^{*1}	3,200	2,470 ^{*1}	3,680
Үйлдвэрийн химийн анализ	Чийг (%)	8.3	0.9	31.3	19.2
	Шатамхай (%)	86.0	74.9	59.9	61.2
	Үл шатах (үнс) (%)	5.7	24.2	8.8	19.6
Хувийн жин *2		0.41	0.43	0.86	0.87

Тайлбар

*1: Тооцсон хэмжээ

*2: Судалгааны багийн хэмжилт

Хүснэгтээр дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 1 дүгээр туршилтын хүрээнд ашигласан бага илчлэгтэй RDF түлш нь нүүрснээс илчлэг чанараар хоёр дахин өндөр байна. Тиймэрхүү илчлэг чанартай байх болов уу гэж тооцож байсан болно.

- 2 дугаар туршилтын хүрээнд ашигласан бага илчлэгтэй RDF түлш нь 1 дүгээр туршилтын хүрээнд ашигласан RDF-тэй харьцуулахад илчлэг чанар нь 60%-д л хүрч байсан бөгөөд хуванцар түүхий эдийг нь үйлдвэрлэх явцад шатааж үйлдвэрлэсэнтэй холбоотой.
- Нөгөөтэйгүүр, 2 дугаар туршилтын хүрээнд ашигласан нүүрсний илчлэг чанар нь 1 дүгээр туршилтанд ашигласан нүүрснээс 1.5 дахин илүү илчлэгтэй байв.

< RDF түлшийг үйлдвэрлэх явцад шатааж буй байдал >



